



СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ

СЭТГҮҮЛ

ДУГААР 2023/02

МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН
ЕРӨНХИЙ ХОРОО



www.m-election.mn



GECMongolia



Монгол Улсын
Сонгуулийн
ерөнхий хороо

СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ

СЭТГҮҮЛ

ДУГААР 2023/02

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ЭРХЛЭГЧ

Д.Бат-Эрдэнэ

Мэдээлэл, судалгаа, сургалтын төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

З.Бадмаараг

Хорооны хэвлэлийн төлөөлөгч-Референт

ЗӨВЛӨХ

Ж.Амарсанаа

Академич, хууль зүйн шинжлэх ухааны доктор

ГИШҮҮД

П.Алтанчимэг

Мэдээллийн технологийн төвийн ахлах референт

Ш.Сүхбаатар

Хууль зүйн ухааны доктор, судлаач

С.Оюунтуяа

Сонгогчдын боловсрол төв ТББ-ын гүйцэтгэх захирал

Ч.Сайнсанаа

Чимид сангийн тэргүүн

МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО

@Бүтээлийн зохиогчийн эрх хуулиар хамгаалагдсан тул олшруулахыг хориглоно.



АГУУЛГА



01 СОНГУУЛЬД
СУРАЛЦАХУЙ



02 ЗУРАГ ТҮҮХ
ӨГҮҮЛНЭ



03 ДУГААРЫН ЗОЧИН



04 СУДАЛГАА



05 ЭРХ ЗҮЙН
ОРЧИН



06 ЦАХИМ СИСТЕМ



07 ХАРИУЦЛАГАТАЙ
СОНГОГЧ
БЭЛТГЭХ
ХӨТӨЛБӨР



08 “СОНГУУЛИЙН
БОЛОВСРОЛ”
КЛУБЫН ҮЙЛ
АЖИЛЛАГАА



09 СОНГУУЛЬ ДЭЛХИЙ
ДАХИНД





СОНГУУЛЬД СУРАЛЦАХУЙ

- Сонгуулийн эрх зүйн зарчим

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



СОНГУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗАРЧИМ¹

БЯРААГИЙН ЧИМИД

Ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар,
Ардын багш, гавьяат хуульч, доктор, профессор

1. ЗАРЧИМТАЙ, ЗАРЧИМГҮЙ ГЭХИЙН УЧИР

Амьдралд “зарчимтай хүн, зарчимгүй этгээд” гэх үг яриа сонсогддог нь үнэлэмжийн чанартай юм. Нэгэнт шийдсэнээ тууштай баримталдаг хэлсэндээ хүрдэг чанарыг “зарчимтай” гэдэг бол тууштай чиг бодлогогүй, амласан шийдсэнээсээ байн байн буцаж булздаг, итгэмжгүй чанарыг “зарчимгүй” гэх маягаар үнэлдэг. Энэ эгэл талаас нь үзвэл зарчим бол бодлогын үндэс, зохион байгуулалтын үндсэн эхлэл, үйл ажиллагааны тогтвортой чиг шугам юм. Бид сонгуулийн бодлого, үйл ажиллагаандаа нийтийн, шууд, эрх тэгш байдлын гэдэг ч юм уу санхүүжилтийн хувьд “хэмнэлттэй”, “үр дүнтэй” гэхчлэн томъёоллыг зарчим хэмээн ойлгож өнө удаан баримталдаг. Үүн лугаа адил сонгуулийн тогтолцоонд, түүнийг зохицуулдаг эрх зүйд, сонгогчийн эрхийг эдлүүлэн хангахад тус бүрт нь тохирсон бодлого баримталдаг. Түүнийг л зарчим гээд байгаа юм.



Сонгуулийн хууль, эрх зүйн бусад хэм хэмжээг тогтоох, сахин биелүүлэх, хэрэглэхдээ нийтээр нэг мөр баримталдаг **үндсэн эхлэл**, сонгуулийн улс төр-эрх зүйн бодлогын **тогтвортой үндсүүдийг** энэ эрх зүйн зарчим гэнэ. Хураангуйлбал сонгуулийн харилцааны эрх зүйн зохицуулалтын тулгуур, уул зохицуулалтыг хангах арга хэрэглүүр болсон **үндсэн эхлэлүүд юм**.

Түүнийг хуульчилж тууштай баримтлах нь үнэлж баршгүй ач холбогдолтой. Уул зарчим нь нийгмийн бодит харилцааг тусгах бөгөөд иргэд, тэдний сонгуулийн нэгдлүүдийн болон сонгуулийг бэлтгэх, зохион байгуулах, нийт байгууллагын үйл ажиллагааны **хууль ёсны хийгээд шударга ёсны үндсэн шалгуур** болдог байна. Зарчмаас хазайвал замаа алдана. “Туушгүй хүн тугалган жадтай адил” гэдэгтэй энэ үг холбоотой.


Сонгуулийн эрх зүй нийтийн эрх зүйд хамаардаг учир зарчим нь:

1. бүх талын, нийтээр зөвшөөрсөн заавал биелүүлэх тулган заасан (императив) шинжтэй;
2. сонгуулийн эрх зүйн янз бүрийн үүсгэл, зарчмын үүрэг, ач холбогдлыг тусгасан өвөрмөц үүрэгтэй;
3. сонгуулийн цогц чанарыг тусгаж харилцан уялдаатай хэрэглэдэг;
4. сонгуулийн харилцааны зохицуулалтын эрх зүйн механизмыг бүрэлдүүлдэг үндсэн хэмжээс болдог;
5. сонгуулийн эрх зүйг Үндсэн хуулийн эрх зүйн дэд салбар болтол хөгжүүлэх чиглэлийг тодорхойлдог зэрэг болно. Өдгөө сонгуулийн эрх зүйн зарчмуудыг өргөсгөн авч үзэх хандлага бий болжээ. Зарчмууд зөвхөн иргэдийн сонгуульд оролцох үзэл хандлагыг төдийгүй ард түмэн засгийн эрхээ хэрэгжүүлэхэд засаг төрөөс үр нөлөөтэй, шийдвэрлэгч чанартай оролцуулах нөхцөлийг хангах үүрэг, ардчилсан ёсны арга хэрэглүүрийг багтаана.

¹ Б.Чимид. Сонгуульд суралцахуй, УБ, 2008, 46-49 дэх тал.

2. ЗАРЧМЫН ТОГТОЛЦОО

Сонгуулийн эрх зүйн зарчим бол ардчиллын жам ёсыг бодитой тусгасан, заавал биелүүлэх, харилцан уялдаа холбоотой хэрэгжих арга хэрэглүүрийн нийлбэр цогц юм. Түүнийг шууд баримтлах чиглэлээр нь дараах гурван бүлэгт хуваана.



1) Сонгуулийг зохион байгуулж явуулах зарчим

- заавал явуулах (эрх баригчдын дур хүслээр биш);
- тогтмол хугацаанд явуулах (эрх баригчдын хүссэн үед биш);
- цаг тухайд нь товлон зарлах (боломж);

- сонгууль нь чөлөөтэй, сонголттой, өрсөлдөөнтэй байх;
- сонгуулийн тогтолцоо янз бүр байж болох (орон орны нөхцөлд нийцсэн);
- сонгууль хуурмаг биш бодитой байх;
- сонгуулийн байгууллага (хороод) хараат бус, эрх, үүргийг нь зөв заагласан байх;
- сонгуулийн болон оролцогч байгууллагууд ил тод ажиллах;
- мэдээлэл үнэн зөв байх;
- олон түмний болон шүүхийн хяналттай байх;



2) Сонгуульд иргэдийн оролцооны зарчим

- бүх нийтээр оролцох;
- эрх тэгш оролцох;

- шууд сонгох;
- чөлөөтэй оролцох;
- саналаа сайн дураар өөрөө нууцаар гаргах;
- сонгуулийн эрхээ шүүхээр хамгаалуулах зэрэг болно.




3) Иргэд байгууллагын нийтээр баримтлах түгээмэл зарчим нь хууль дээдлэх ба шударга ёс мөн.

- Зарим оронд олон сонгууль, ард нийтийн санал асуулга давхардуулахыг хориглох зэрэг бусад зарчим байдаг аж.







02

Зураг түүх өгүүлнэ.

- Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хороо дэлхийд данстай байгууллага

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО ДЭЛХИЙД ДАНСТАЙ БАЙГУУЛЛАГА

З.БАДМААРАГ

Сонгуулийн ерөнхий хорооны хэвлэлийн төлөөлөгч-Референт



Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хороо нь Дэлхийн сонгуулийн байгууллагуудын холбоо болон Азийн сонгуулийн байгууллагуудын холбооны албан ёсны гишүүнчлэлтэй. Сонгуулийн Ерөнхий Хороо 2013 онд Дэлхийн сонгуулийн байгууллагуудын холбоонд, 2014 онд Азийн сонгуулийн байгууллагуудын холбооны Удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогджээ.





Дэлхийн сонгуулийн байгууллагуудын холбоо буюу A-WEB нь дэлхийн улс орнуудад тогтвортой ардчиллыг төлөвшүүлэх, чөлөөт, шударга, ардчилсан сонгуулийн тогтолцоог хөгжүүлэх, түүнчлэн сонгуулийн удирдлагын байгууллагуудын хамтын ажиллагааны сүлжээг бий болгох, сонгуультай холбоотой мэдлэг, мэдээлэл, туршлагаа хуваалцах, мэргэжилтнүүдийг сургах, мэргэшүүлэх замаар сонгуулийн удирдлагад оролцогчдын чадавхийг нэмэгдүүлэх, ардчиллыг тогтоож буй шилжилтийн үе дэх улс орнуудын сонгуулийн байгууллагуудад дэмжлэг үзүүлэн ажилладаг олон улсын төрийн бус байгууллага юм.

Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний Сонгуулийн Комисс анх 2010 онд ДСБХ-г байгуулах санаачлагыг Азийн сонгуулийн байгууллагуудын холбоонд дэвшүүлж, улмаар 2011 онд БНСУ-д

хуралдсан Сөүлийн форумын тогтоолоор дэмжин баталсан. ДСБХ нь одоо Ази, Африк, Америк, Европ болон Номхон далайн арлын 110 орны сонгуулийн удирдлагын 119 байгууллагыг эгнээндээ нэгтгэн идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Холбооны удирдах дээд байгууллага нь Ерөнхий Ассамблей, Удирдах зөвлөл.

2013 онд Ерөнхий Ассамблейн анхдугаар хуралдааны үеэр Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хороо тус Холбоонд гишүүнээр элссэн бөгөөд элсэн орсон цагаасаа Холбооны зүгээс зохион байгуулж буй арга хэмжээнүүдэд идэвхтэй оролцож ирлээ. ДСБХ-ноос жил бүр зохион байгуулдаг хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, сонгуулийн байгууллагын ажилтны солилцооны хөтөлбөрт Сонгуулийн Ерөнхий Хорооны болон сонгуулийн зохион байгуулалтын асуудлаар хамтран ажиллагч төрийн болон төрийн бус

байгууллагуудын ажилтнуудыг байнга хамруулж байна. Харин Азийн сонгуулийн байгууллагуудын холбоо нь 1998 онд байгуулагдсан бөгөөд Азийн 20 улсын сонгуулийн төв байгууллага тус Холбооны гишүүнээр элссэний нэг нь Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хороо юм. Сонгуулийг шударгаар зохион байгуулах үүрэг бүхий, хараат бус, бие даасан институцийг бий болгох дэмжлэг тусалцаа үзүүлэх, нээлттэй, ил тод сонгуулийг дэмжих, Азийн сонгуулийн байгууллагуудын ажилтнуудыг мэргэшүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, сонгуультай холбоотой мэдээлэл, судалгааг боловсруулах, харилцан мэдээлэл солилцох зорилготой тус холбооны Удирдах зөвлөлийн гишүүнээр манай улс 2014 оны 10 дугаар сарын 29-нөөс 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдөр хүртэл сонгогдон ажилласан түүхтэй.



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

A vertical teal graphic element. The top half features a light teal background with a darker teal triangle pointing downwards. The bottom half is a solid dark teal rectangle containing the white number "03".

03

ДУГААРЫН ЗОЧИН

- Т.Амарзаяа: "Сонгуулийг ажиглах нь бидний хувьд ихээхэн үнэ цэнэтэй үйл явдал"

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

13



**Т.АМАРЗАЯА:
СОНГУУЛИЙГ
АЖИГЛАХ
НЬ БИДНИЙ
ХУВЬД
ИХЭЭХЭН ҮНЭ
ЦЭНЭТЭЙ ҮЙЛ
ЯВДАЛ**

*“Шударга сонгуулийн төлөө Иргэний нийгмийн хяналт” сүлжээний гишүүн,
“Бодлогод залуусын хяналт” ТББ-ын Гүйцэтгэх захирал Т.Амарзаяа
дугаарын зочноор урьж ярилцлаа.*

**Хамгийн анх энэ салбарт
орж ажиллах шалтгаан
тань юу байсан бэ?**

БЗД-ийн 92-р сургуулийг төгссөн, Эрдэнэтолгойд байдаг гэдгээр нь хүмүүс мэдэх байх. Багаасаа

нийгмийн идэвхтэй, хичээлдээ сайн, бараг 10 жил ангийн дарга хийсэн. /инээв./ Сурагчдын зөвлөлд ажиллаад явж байтал надад урилга ирсэн. Английн хүүхдийг ивээх сангийн салбар төв манай сургуулийн ойролцоо

байгуулагдаад ажиллаж байгаа, тэнд хүүхдийн эрх, оролцооны чиглэлээр төсөл хэрэгждэг, хүүхэд хамгааллын чиглэлээр чанартай ажлууд зохион байгуулдаг газар байсныг тухайн үед 14-15 настай хүүхэд би тэгэхэд мэдэв. Олон

нийтэд түшиглэсэн хүүхэд, хөгжил хамгааллын 6 төвтэй, түүний нэг нь урьсан байсан. Тэнд очиж ажиллаад иргэний нийгмийн салбартай холбогдох эхлэл тавигдсан гэх юм уу даа. Хүүхэд, хөгжил хамгааллын төвд сургуулийнхаа хүүхдүүдийг төлөөлж, очиж ажиллаад, тэнд хүүхдийн эрхийн клуб байгуулаад, сургалтуудад суугаад, бидэнд чөлөөт цагаа зөв өнгөрүүлэх газар угаас ховорхон байсан үед жинхэнэ таатай орчин байв. Хөгжим, сагсны дугуйлан хичээллээд, есөн зүйлийн үйл ажиллагаа явсан. Хоёр гурван жилийн дараа буюу 2008 онд төвүүдийн хүүхдүүдийг цуглуулж, анх удаа НҮБ-ын Хүүхдийн эрхийн хороонд илтгэл бичих багт орж, зуны гурван сарын турш 30 хүүхэдтэй баг болоод ажилласан. Миний хувьд зуны амралтаараа эгчдээ туслаж ажил хийдэг байлаа. Тэр багт бусад шигээ бүрэн дүүрэн оролцоотой байж чадаагүй ч илтгэлээ бичиж дууссаны дараа тухай н үедээ 18 настай, үе тэнгийн зургаан хүүхэд нь нийлээд "Хүүхэд хүүхдийн төлөө" нэртэй байгууллага байгуулаад, дэргэдээ

хүүхдийн клубээ аваад ажиллаж эхэлсэн. Энэ үед ч Хүүхдийг ивээх сангийн дэмжлэг үргэлжилж байв. Би тус байгууллагад 2012 он дуустал ажилласан. Сургуулиа ч төгссөн. Мэргэжлээрээ ажиллаа гээд байж байтал МОНФЕМНЕТ үндэсний сүлжээний Ц.Мандхайхатан гэдэг үеийн охинтой хамтран ажиллаж боломжгэнэт гарчирэв. Бүхнийтийн боловсролын төлөө эвслийн гарын авлагыг боловсруулахад хамтраад бид ойр ойрхон уулзаж ярилцдаг болов. Тэр үед нэг зүйлд санал нэгдсэн нь манай улсад залуучуудын

байгууллага алга, байсан ч хараат бус, бие даасан нь ховор. Бидний үеийнхний оролцоо бага, уншихгүй, судлахгүй байна. Ялангуяа бодлогын асуудалд залуучууд бодлогын гадна үлдэж, тэдэнд хүрдэггүй. Та нар чадахгүй, залуучууд бол зүгээр ирээд сонсоход болно гэх зэргээр гоёл, чимэг төдий ашигладаг, оролцоо хумигдмал шинжтэй байсныг Мандхай бид хоёр анзаарч ярилцаад үнэт зүйл нэгтэй залуусаа цуглуулсан. Тэр үед Б.Болорсайхан, Т.Энхжаргал, Г.Уянга, ЛГБТ төвийн захирал байсан Ц.Отгонбаатар нарын хүмүүсийг урьж дуудан "Ийм байгууллага байгуулах гэж байна. Та нар хамтрах уу?" гээд

“

...Ажиглалтын явцад асуудал үүсвэл Сонгуулийн ерөнхий хороо руу мэдэгдэж, яаралтай арга хэмжээ авахуулна. Бүгдийг холбон зуучилж, асуудлыг зохицуулаад байж байдаг чухал алба бий. Тэндээс их эх оронч мэдрэмжийг авдаг.

”

зорилгоо танилцуулсан. Бид бүтэн жил тойрон явсан. Байгууллагаа шууд байгуулчихаагүй. 2013-2014 онд оффисгүй, кофе шопод уулзаж, байгууллагадаа ямар нэр өгөх, дүрмээ хэрхэн тогтох тухай ярилцаж явсаар 2014 оны намар "Бодлогод залуусын хяналт" ТББ-аа албан ёсоор үүсгэн байгуулсан. Харин тэр цагаас хойш тасралтгүй, тууштай ажиллаж байна. Байгуулахаасаа өмнө бид "Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн сүлжээ"-ний үйл ажиллагаанд оролцож, иргэний нийгмийн хараат бус

ажиглалтыг явуулж үзсэн. Үүнээс хойш нийтдээ 5 удаагийн сонгуульд ажиглагчаар ажиллажээ.

Сонгуулийн хараат бус ажиглагчаар ажиллахын ач холбогдлыг тодруулбал? Та бүхэн зорьсон үнэт зүйл, зорилгодоо хүрч чадсан уу? Залуучууд та нартай нэгдье гэвэл хаана хандах уу?

Дэлхийн бусад улс оронд 100 жилийн түүхтэй төрийн бус байгууллага жинхэнэ утгаараа оршин тогтнож,

соёл нь ч төлөвшсөн байдаг. Бидний зорилго бол тэр. Байнгын үйл ажиллагаатай, нийгмийн чиг шугам болж байдаг. Тийм олон жилийн настай байгууллага болохыг зорьж байна. Мандхай бид хоёрын хувьд одоогоор амьдралынхаа 10 жилийг зориулжээ./ инээв./ Залуучуудын асуудал орхигдсоор ирснийг сая "Ковид-19"-ийн үед ч тодорхой харагдлаа. Нийгмийн аль нэг бүлгийг онцлоод,

залуус мартагддаг. Шийдвэр гаргах түвшинд оролцоо багатай.

Ковидын үед залуусын асуудал хэрхэн орхигдож байсан бэ?

Манайх дэргэдээ "Залуусын давалгаа" гэж клубтэй. Гэр хорооллын залуустай ажилладаг. Тэр клубт ажилладаг залуус маань Боловсролын эвслийн шугамаар үйл

“

Анхнаасаа бид сонгуульд иргэний нийгмийн оролцоог хангах, сонгуульд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлж, ардчиллыг хамгаалахад хувь нэмрээ оруулах зорилготой орж ирсэн.

ажиллагаанд суурилсан судалгаа хийх буюу “Youth led action research” хэмээх аргачлалыг заалгаж, тулгамдаж буй асуудалтайгаа хэрхэн нүүр тулж, тухайн асуудлыг “гаргаж” ирэх онлайн сургалтад дахин хамрагдаад “Ковид ба Залуус” судалгааг хийсэн. Онцгой халамж шаардагдсан бүлгийн залуусын эрх зөрчигдсөн байдалтай байгааг тэр судалгааны үр дүнд хөндөж тавьсан. Энэ үед залуусын асуудлаар хийсэн өөр нэг ч судалгаа байгаагүй гэдгийг онцлох нь зүйтэй байх.

Хараат бус, бие даасан байдлаа хадгалж үлдэхийн үнэ цэнэ юунд оршдог вэ?

Бид яагаад хараат бус байх ёстой вэ гэвэл бид нийгмийг төлөөлж байгаа, залуучуудыг төлөөлж байгаа. Тийм учраас хэзээ ч төрөөс, улс төрийн намуудаас санхүүжилт авч болохгүй. Яваандаа соёл нь тогтвол иргэдээс, зарим бизнесийн салбараас хандив авч магад. Гэхдээ бид одоогоор авсан зүйлгүй. Авч гэмээнэ архи, тамхи, уул уурхай, хөдөлмөрийн мөлжлөгтэй газраас хэзээ ч авахгүй гэсэн ерөнхий зарчим бидэнд бий. Зарчмаа бариад явж байхад хараат бус байдлаа алдахгүй. Анхнаасаа бид сонгуульд иргэний нийгмийн оролцоог хангах, сонгуульд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлж, ардчиллыг хамгаалахад хувь нэмрээ оруулах зорилготой орж ирсэн. Нээлттэй нийгэм форумын дэмжлэгтэй, зорилго, үйл ажиллагаа нь ойлгомжтой, тодорхой байсан учраас эргэлзэж, тээнэгэлзэх зүйл гараагүй байх. 2019 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцүүлэх үед бид дэмжиж, сошиал акц хийсэн. Анх удаа УИХ-ын 62 гишүүний өргөн барьсан төслийг дэмжсэн. Тэгэхэд хардалтад өртсөн. Түүний дараа нэр бүхий улс төрийн нам, эвслээс яг түүн шиг акц хийж өгөхийг

хүссэн. Хүлээж авахгүй гэдгээ илэрхийлсэн. Бидний хүүхдүүдийн ирээдүйд хэрэгтэй учраас тухайн үед Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж батлуулахын төлөө нойр, хоолоо хасан ажилласан. Дараа нь Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад мөн оролцоотой ажилласан. Энэ бол ардчиллын төлөө, ирээдүйн төлөө хараат бусаар хичээж ажилласан залуусын эв санааны нэгдэл байсан. Улс төрийн шинжтэй аливаа үйл явдал өрнөх үед хэвлэл мэдээллийн байгууллагууд хамгийн түрүүнд манайд хандахыг эрхэмлэх болсон нь бидний шударга ажилласны үр дүн, үнэлэмж, илэрхийлэл гэж боддог.

Төрийн бодлогод залуучуудын хяналт, оролцоог төлөвшүүлэх, хараат бус иргэний нийгмийн байгууллагын соёлыг төлөвшүүлэхийн тулд ямар шалгуур давдаг бол?

Бидний хувьд тодорхой шалгуур давсаан. Нэгдүгээрт, шантрахгүй тууштай байдал. Ямар нэгэн мөнгөний санал, ашигтай байх зэрэг олон янзын санал ирж байгаа. Гэхдээ энэ бол бидний үнэт зүйл биш юм. Хэрвээ хэн нэгний эрх ашигт үйлчилдэг бол ингэж оршин тогтнох боломжгүй. Жишээ нь: нэг яамны төрийн нарийн бичгийн дарга иргэний нийгмийн хуулийг эсэргүүцсэний төлөө, хэлэлцүүлгийн үеэр “Танай сэтгүүлчдийн хөтөлбөр чинь манайхаас санхүүжилт авдаг” гэж жишимгүй хэлсэн удаа бий. Нэг ёсондоо бидний нэр хүндэд бүдүүлгээр халдсан. Гэтэл тэр нь яамны мөнгө биш, Швейцар Монгол хоёр улсын хооронд хийсэн гэрээний дагуу хэрэгжсэн төслийн хүрээнд манай байгууллага тэр төслийн шаардлагыг хангасан

учраас хэрэгжүүлсэн хөтөлбөр. Тус яамны мөнгө огт биш гэдгийг бусад хүмүүс ойлгохгүй. Бидний 2018 онд эхлүүлсэн ажил. Нэгэнт эхэлсэн бол дуусгах ёстой л ажил байсан. Манай санхүүжилтийг 5-6 сар гацаасан гэх мэтийг дурдвал амаргүй. Олон сорилт, бэрхшээлтэй тулгарч яваа.

Манай улсад сонгуулийн хараат бус, бие даасан ажиглагчдын соёл нэгэнтээ төлөвшин тогтжээ. Үүнд залуучууд та бүхний оролцоо ч бий. Ялангуяа оролцогч иргэний нийгмийн байгууллагын төлөөллийн хувьд таны бодлыг сонсмоор санагдлаа?

Наадам болохоор уяа сойлгоо өөрөө тааруулаад, дүүхэлээд байдаг морь байдаг даа. Түүн шиг сонгууль болохоор огшоод, догдлоод эхэлдэг. /инээв/ Сонгуулийг ажиглах нь бидний хувьд ихээхэн үнэ цэнэтэй үйл явдал юм.

Сонгуулийн ажиглагчаар хэдэн настайдаа анх ажиллаж эхэлсэн бэ?

Хамгийн анх 22 настайдаа сонгуулийн ажиглагчдын баг ахалж, бас ажиглагчаар ажиллаж байлаа. Тухайн үед сонгуулийн боловсрол гэж цээжээ дэлдэж явснаас илүүтэй, өөрийн биеэр санал авах байруудаар ороод, олон хүний сонгох эрхийг хамгаалаад, нөгөө талаар нэр дэвшиж буй хүмүүсийн сонгогдох эрхийг хамгаалаад, Монгол Улсын төрийн дуулалд эгшиглэхийг сонсоод ажиллах хариуцлагатай бөгөөд бахдам үүрэг оногдсон. Төлөвлөгөөнийхөө дагуу, ажиглагчдын дүрмийн дагуу арын албанд хоёр ээлжээр, ажиглагчийнхаа пудволкыг өмсөөд ажиглалт хийх үед хэнээс ч хараат бус, шударга байдлын төлөө ажиллах сайхан мэдрэмж байдаг. Ялангуяа арын албанд ажиллах үед бусад ажиглагчдынхаа аюулгүй байдал, олон зүйлийг тооцоолох ёстой. Сүүлийн ажиглагч ажиглалтаа

дуусгаад харьж амрах хүртэл ажилладаг. Ажиглалтын явцад асуудал үүсвэл Сонгуулийн ерөнхий хороо руу мэдэгдэж, яаралтай арга хэмжээ авахуулна. Бүгдийг холбон зуучилж, асуудлыг зохицуулаад байж байдаг чухал алба бий. Тэндээс их эх оронч мэдрэмжийг авдаг. /инээв./ Сонгууль дөхөхөөр ажиглагчдын багаа бүрдүүлж, сайн дурын ажиглагчдыг бэлддэг. 50, 50-иар нь баг болгож, сургалт, мэдээлэл өгөх гээд амаргүй ажилтай. Ялангуяа Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулиар цар тахлын дэглэмтэй үе таарсан нь зарим хичээл, сургалтаа цахимаар явуулсан. Өөрт мэдэрсэн тэр мэдрэмж, ажил хэрэгч уур амьсгалыг шинэ ажиглагчдаа дамжуулж өгөх их чухал байдаг. Тэдэнд ойлгуулахын тулд ардчилал гэж юу юм, ямар үнэ цэнээр бидэнд олдсон зүйл болохыг, яагаад хамгаалах ёстойг, сонгуулийн ач холбогдлыг таниулахын тулд оролцооны аргуудыг ашиглана. Заримдаа жүжигчилсэн тоглолтоор үзүүлнэ. Учир нь манайд ажиглагч





“

900 гаруй ажиглагч бий. 2020 оны сонгуулиар бид 5 аймагт ажиглагч бэлдсэн. 2021 оны сонгуулийн үеэр аймгуудаас гадна дэлхийн 3 улсад ажиглагч бэлдэж, хамтран ажилласан.

хийхээр ирсэн хүүхдүүдийн олонх нь 18 настай, өөрөө дөнгөж анхны сонгуульд оролцож, саналаа өгөх гэж байгаа залуу сонгогч байдаг. Санал авах байрны тухай ямар ч төсөөлөлгүй ирдэг. Хуруугаа уншуулдаг машины загварыг савангаар хийгээд, хар хуулга нааж, үзүүлэнг нэг бүрчлэн гараараа хийгээд “Эндээс нь ийм юм гарч ирнэ” гэх мэтээр нэг бүрчлэн үзүүлдэг. Орчноо мэдэрч, ажиглагчийн баримтлах зарчим, үнэт зүйл, мэдрэмжийг шинэ ажиглагчдадаа шилжүүлж өгөх нь бидний үүрэг. Энэ бол сайн дурын ажил. Мөнгө аваад хийдэг зүйл биш. Гол нь сайн дурын үйл явц гэдгийг ухуулж, ойлгуулах, хамт бахархах сэтгэл төрүүлэх маш чухал.

Сонгуулийн ажиглагчдын багт нийт хэчнээн залуусыг бэлтгэсэн бэ?

900 гаруй ажиглагч бий. 2020 оны сонгуулиар бид 5 аймагт ажиглагч бэлдсэн. 2021 оны сонгуулийн үеэр аймгуудаас гадна дэлхийн 3 улсад ажиглагч бэлдэж, хамтран ажилласан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн үйл явцыг Америк, Япон, Солонгос улсад ажиглалт явуулсан. Олон жил сонгууль ажигласан туршлагатай ажиглагчдаас маань тэдгээр улсуудад ажиллаж, амьдарч байсан болохоор нэмэлт сургалт явуулах ч шаардлага гараагүй юм. Солонгосын ажиглагч бол шууд хамтрах саналыг уриалгахан хүлээж аваад “Эндээс бас ажиглаж болох юм уу” гээд ажиглагчдын багийнхнаа бэлдэж байх жишээтэй.

Сонгуулийн ажиглагчид ямар шалгуур тавьдаг талаар хоёулаа уншигчдад ярьж өгье?

Нэгдүгээрт, төрийн албан хаагч биш байх ёстой. Хоёрдугаарт, нам бус

байх. Гурав дахь нь мэдээж 18 нас хүрсэн байх гэсэн гурван шаардлага тавьдаг. Мэдээж улс төрийн хүсэл зоригоо илэрхийлэхдээ дэмжиж буй нам, эвслээ сурталчлахыг хорьдоггүй. Гэхдээ хэрвээ Та иргэний нийгмийн ажиглагч болсон бол социал хуудсаараа үзэл бодлоо илэрхийлэхдээ болгоомжтой хандах ёстойг сануулдаг. Ямар нэгэн нам, эвслийн шоу, цэнгээнд явах гэх мэт үйлдэл байж болохгүй. Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт сүлжээний цахим болон социал хуудас <https://www.sanal.mn/>, Бодлогод залуусын хяналт ТББ-ын фэйсбүүк хуудсаараа залуу ажиглагчдыг бүртгэж авах тухай зараа гаргадаг. Ажиглагчдын мэдээлэл солилцох цахим бүлэгтэй. Сонгуулийн хууль тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлт, анхаарах зүйлсээ сургалтаараа олгодог.

Хараат бус, бие даасан ажиглагчид нь ардчилсан сонгуулийн үнэт зүйл гэж үздэг. Залуу сонгогчдод сонгуулийн үйл явцад оролцох оролцоог идэвхжүүлж ирсэн танай хамтын олонд баяр хүргэхийн ялдамд сонгуулийн талаарх санал бодлыг тань сонсох сонирхолтой байна? Ажиглагчдын журам, тавигдах шаардлага зэргийг манай Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан. Сонгуулийн ажиглагчийн соёл хэдийнэ төлөвшчихлөө. Одоо цаашид юуг илүү боловсронгуй болгомоор санагддаг бэ?

Бид сонгуулийн санал авах өдөр ажиглалт хийхээс гадна 2017 оноос эхлэн сонгуулийн зардлын тайланд дүн шинжилгээ хийдэг болсон.

Сонгууль, ялангуяа сонгуулийн зардал нь иргэдийн халааснаас гарч байдаг. Иргэд хамаагүй мэт, улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдээс санхүүждэг гэж хардаг ч эцсийн дүндээ татвар төлөгч бидний халаастай холбогддог учраас анхаарахгүй үлдээж болохгүй зүйл. Бидний мөнгө учраас сонгуулийн зардлыг бууруулах, тайланг ил тод болгох шаардлагатай гэсэн байр суурьтай явж ирсэн. Хэвлэл мэдээллийн мониторинг гээд олон чиглэлээр, олон байгууллагатай холбогдоод явчихдаг. Иргэний нийгмийн байгууллагынхан бид сонгууль бүрээр ажигласан, явуулсан мониторингийнхоо дүнд үндэслэн холбогдох байгууллагуудад зөвлөмжөө хүргүүлдэг. Сонгуулийн үеэр үүссэн асуудлыг ирэх сонгуульд давтуулахгүй байх, бодлогын баримт бичигт саналаа тусгуулах, шинэчлэх зэргээр саналаа илэрхийлдэг. Сонгуулийн ажиглалтын эхэн үед хэсгийн хороодын ахлагч нар гадаад үзэмжээр хандаж, жаахан хүүхэд юу хийж явна гэсэн үл тоомсорлосон байдалтай нүүр тулж ирсэн үе бий. Том биерхүү, пиджактай залууг уриалгахан хүлээж аваад, мань мэтийг годгор охин гэж харилцах хүнтэй ч тааралдсан. Ялгаварлалт өндөртэй. Бүрдүүлэх баримт, бичгийн жагсаалт урт. Үйл явц төвөгтэй байсан үеийг бодвол одоо ажиглагчдыг бүртгүүлэхэд бэрхшээл багатай, дарга нар нь иргэний нийгмийн ажиглалт гэдгийг таньж мэддэг болсон байна. Өнгөрсөн сонгуулиар санал авах бүх байрыг цахимаар нэгэн зэрэг ажиглаж болдог болсон, нууц кодыг нь аваад сонгуулийн хорооныхонтой зэрэгцээд хараад суух боломж бүрдсэн зэрэг дэвшилттэй зүйл олон байгаа. Сонгуулийн ерөнхий хороотой бүтээлчээр хамтран ажилладаг болсон. Урьд нь хаана, хаанаа хүндрэлтэй асуудал байсныг нуухгүй.



Үндэсний аудитын газарт сонгуулийн зардлын мониторингийн чиглэлээр ил тод болгох хийх зүйлсээ санал, зөвлөмж байдлаар хүргүүлээд явж байна. Харьцангуй нааштай яваа. Зөвлөмжийг авдаг болсон.

Та бүхний хувьд зорьсондоо хүрсэн үү? Залуусын улс төрийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх, ялангуяа хяналтыг бий болгоход мэдлэг, ойлголттой, мэргэших шаардлагатай байх, энэ чиглэлээр цаашид хэрхэх вэ?

Залуучуудын улс төрийн оролцоо манай улсын хувьд муу хэвээр байгаа. Залуу улстөрчид, залуу албан тушаалтныг “цүнх баригч”, “юугаа

мэддэг юм” гэсэн үл тоомсорлосон хандлагаар хүлээж авдаг. Улс төр гэдэг зүйл залуусын дунд нэр хүндгүй болсон. Хамгийн арчаагүй хүн тийшээ ордог, авлигач мэтээр ойлгодог. Улс орнуудын сорилтыг туулж байгаа. Энэ утгаараа манай байгууллага чухал үүрэг хүлээж байна. Сонгуультай холбоотой хууль тогтоомжууд, ялангуяа Улс төрийн намын тухай хуулийн төсөлд бид оролцож, байр сууриа илэрхийлнэ. Намуудын төлөвшил, дотоод ардчилал, засаглал зэрэгт бодит шинэчлэл хийх боломж бүрдүүлэхэд анхаарах, одоо хэлэлцүүлж буй шинэ хуулийн төслүүдэд “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн сүлжээ”-ний санал, зөвлөмжөө бичгээр өгч, олон нийтэд танилцуулж ажиллаж байна. Хууль баталж байгаа үйл явцад иргэдийн оролцоог маш сайн хангаж ажиллах ёстой. Жишээлбэл, Улс төрийн

намын тухай хуулийн төсөлд юу тусгасныг өргөн барьсныхаа дараа ил болгодог, УИХ-ын сонгуулийн тухай хуулийн төслийг ч ялгаагүй. Өргөн барихаас нь өмнө олж үзэх гэтэл олддоггүй. Аль хэдийнэ өргөн барьсны дараа нийтэд ил болж байх жишээтэй. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг гэнэт оруулж ирээд л... Бас л төсөл нь харагдахгүй байснаа гэнэт өргөн барьдаг дутагдалтай. Ил тод, иргэдэд мэдээлэл өгсний дараа өргөн барих ёстой. Сонгогчийн боловсролын тухайд бид “Залуус сонгуулийн амлалтыг хянах нь” төслийг хэрэгжүүлсэн. 4-5 аймаг, Улаанбаатар хот дахь төрийн бус байгууллагуудыг оролцуулсан сүлжээг байгуулсан. Сонгуульд нэр дэвшээд ялалт байгуулсан нам, эвслийн мөрийн хөтөлбөрийг хянах, өөрөөр хэлбэл, ялсан намын мөрийн хөтөлбөр Засгийн газрын мөрийн хөтөлбөр болно. Тиймээс тус сүлжээгээр дамжуулан УИХ-ын 2020 оны ээлжит сонгуулиар амласан амлалтын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж байгаа. Мөрийн хөтөлбөрийн дагуу мэдээлэл цуглуулж эхэлсэн. Ингээд эхлэнгүүт зарим яамны сайд, аймгийн Засаг дарга нар цочирдож байх шиг. Бодит байдал, амлалт хоёрын харьцуулалт, ажиглалтыг явуулаад хоёр жил өнгөрчээ. Датагаа дүрсжүүлж, харьцуулж дүгнэх боломжтой болсон. Бусад залуусын байгууллагаас чуулганаа тасалдаггүй гишүүн, ирц оролцоо зэргийг мэдээлээд, хяналт тавиад, залуус оролцоод ирэхээр эерэг өөрчлөлт харагдаж эхэлж байна. Ингэж гэмээнэ сонгуулийн боловсрол жинхэнэ утгаараа биеллээ олно. .

Цаг зав гаргаж ярилцсанд баярлалаа.

Ярилцсан: З.Бадмаарэг
(Сонгуулийн ерөнхий хорооны хэвлэлийн төлөөлөгч)

“ ТӨМӨРБААТАРЫН АМАРЗАЯА ЗОЧНЫ НАМТАР

МЭРГЭШСЭН БАЙДАЛ:

- Хүүхдийн эрх, оролцоог дэмжих;
- Залуучуудын бодит оролцоог дэмжих;
- Иргэдийн бүлгийг дэмжих, бүлгийн тогтвортой байдлыг хангах;
- Бодлогын асуудлаар залуус, иргэдийн бүлгийг чадавхжуулах;
- Бодлогын нөлөөлөл явуулах.

АЖЛЫН ТУРШЛАГА:

- “Бодлогод залуусын хяналт” ТББ-ын Гүйцэтгэх захирал (2021 оноос)
- “Бодлогод залуусын хяналт” ТББ-ын ерөнхий менежер (2020 он)
- ХЗДХЯ, ШХА-ын “Иргэдийн оролцоо-II” төслийн Залуучуудын оролцоо хариуцсан зөвлөх (2019.05-12 сар)
- “Бүх нийт боловсролын төлөө!” иргэний нийгмийн хөтөлбөрийн ажилтан (2018-2019 он)
- “Бодлогод залуусын хяналт” ТББ-ын менежер (2015-2018 он)
- Японы хүүхдийг ивээх сангийн “Хүүхдийн төлөөх төсөв” номын туслах редактор (2014 он)
- Японы хүүхдийг ивээх сангийн “Сайн засаглалд хүүхдийн оролцоо амин чухал төсөл”-ийн хороо дүүргийн хүүхдийн оролцоог дэмжих гэрээт ажил (2014 он)
- “Хүүхэд хүүхдийн төлөө” ТББ-ын Гүйцэтгэх захирал (2009-2013 он)


ИРГЭНИЙ НИЙГЭМ, САЙН ДУРЫН АЖЛЫН ТУРШЛАГА:

- “Лийд Монголиа” хөтөлбөрийн төгсөгчдийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн (2022 оноос)
- “Эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөр”-ийн төгсөгчдийн холбооны удирдах зөвлөлийн гишүүн (2019-2020)
- Сургуулийн эцэг эх, багшийн үндэсний нэгдсэн холбооны үүсгэн байгуулагч (2019 оноос)
- “Бодлогод залуусын хяналт” ТББ-ын үүсгэн байгуулагч, удирдах зөвлөлийн гишүүн (2014 оноос)
- Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээний гишүүн (2010 – 2013 он)
- Хүүхдийн оролцооны үндэсний сүлжээний гишүүн (2010 – 2013 он)
- “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн Удирдах зөвлөлийн гишүүн (2012-2013 он)
- МОНФЕМНЕТ үндэсний сүлжээний Удирдах зөвлөлийн гишүүн (2012-2013 он)

БОЛОВСРОЛ:

- МУИС-ийн Улс төр судлалын магистрант 2022 оноос
- СУИС-ын Радио Телевизийн сургуульд “Радио – Телевизийн сэтгүүлч” мэргэжлээр бакалаврын зэрэг хамгаалсан (2008-2012 он)
- “Мэжикчойс” сургалтын төвийн “Санхүү бизнес”-ийн мэргэжлийн сертификаттай сургалтыг дүүргэсэн (2010 он)
- Нийслэлийн Баянзүрх дүүргийн 92-р дунд





04

СУДАЛГАА

- Сонгуулийн тогтолцоо улс орны хөгжилд хэрхэн нөлөөлдөг вэ? Монголчууд ямар тогтолцоог сонгох нь үр дүнтэй вэ?

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

23

МОНГОЛ УЛСАД СОНГУУЛИЙН ХОЛИМОГ ТОГТОЛЦОО ЯАГААД ТОХИРОМЖТОЙ ВЭ?

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант, магистрантуудын баг:
Г.ЦОЛМОНГЭРЭЛ, Ц.ГАНЗОРИГ, Ж.ГАНЧИМЭГ, Ч.ДЭЛГЭРЦЭЦЭГ,
Б.ДОРЖПАГАМ, Б.МАНДХАЙ, Б.МӨНХЗУЛ, Ц.НАЦАГДОРЖ, Б.СУВД-ЭРДЭНЭ
Зөвлөгч багш: Ж.АМАРСАНАА
Академич, хууль зүйн шинжлэх ухааны доктор



УДИРТГАЛ

Сонгох ёс нь дэлхийн үзэгдэл¹ бөгөөд Монгол Улсад ХХ зууны 20-иод онд орчин цагийн сонгуулийн үзэл санаа тодорхой хэлбэрээр нэвтэрч, тухайн цаг үеийн өнгө төрхийг илэрхийлэн өвөрмөц хэв шинжтэй хөгжсөөр ирсэн. Хураангуйлбал, Монголд 1923 оноос нутгийн Ардын Хурлуудыг, 1924 оноос Улсын Их Хурлыг, 1990 оноос Улсын Ерөнхийлөгчийг сонгох ёс журмыг хуульчлан тогтоож, улс даяар дагаж мөрдүүлэв. Эл гурван зүйл сонгууль түүхэн үе бүртээ тус бүрийн өвөрмөц зарчим, арга журамтай явж иржээ.

Харин 1990 онд социалист хэв маягийн сонгуулийн хуучин тогтолцоог халж, "Анхны ардчилсан сонгууль" үүсэж хөгжих эхлэл тавигдсан байна.

1.Гуравдугаар үе буюу 1990 оноос өнөөг хүртэл үргэлжилж буй **ардчилсан сонгуулийн** үүсэл, хөгжлийн үе.

"**Анхны ардчилсан сонгууль**" гэж нэршсэн АИХ-ын 1990 оны сонгууль нь **хуучин тогтолцоог хэлбэрдэлтээс гаргах үүслийг тавьжээ**. Тэр цагаас хойш Монгол Улсын Их Хурлын сонгууль 1996, 2000, 2004, 2016 онд жижиг тойрог бүхий мажоритар тогтолцоогоор, 1992, 2008, 2020 онд томсгосон мажоритар тогтолцоогоор, 2012 онд **холимог тогтолцоогоор** явагдсан байна. Ийнхүү манай улс мажоритар тогтолцоогоор 20-иод жил явсан,

ингэхдээ томсгосон мажоритар тогтолцоог 3 удаа, холимог тогтолцоог 1 удаа туршиж, сонгуулийн багагүй туршлага хуримтлуулсан.

Сонгуулийн тухайд "Сонгох ёс", "Сонгох, сонгогдох эрх", "Сонгуулийн харилцаа", "Сонгуулийн тогтолцоо", "Сонгуулийн эрх зүйн тогтолцоо" гэсэн нэр томъёонууд бий. Хууль зүйн шинжлэх ухааны цөөн бус ойлголт, нэр томъёо нь "Сонгуулийн эрх зүйн шинжлэх ухааны тогтолцоо", "Сонгох аргын тогтолцоо", "Сонгуулийн байгууллагын тогтолцоо", "Идэвхтэй, идэвхгүй эрх" гэх зэргээр улам нарийсдаг. Эдгээрийг энд нэг бүрчлэн тайлбарлах боломжгүй. Тиймээс "Сонгуулийн тогтолцоо", "Аргын тогтолцоо" хоёрын харилцан хамаарал, ялгаатай байдлыг авч үзэв. Сонгуулийн болон аргын тогтолцооны нэгдэл нь бусдынхаа суурь ухагдахуун мөн. Түүний анхдагч нь иргэдийн **сонгох, сонгогдох** эрх чөлөөний тухай ойлголт бөгөөд үүнээс улбаалан "Сонгуулийн эрхийн тогтолцоо" хэмээх өөр том ухагдахуун бодитой оршдог. Эдгээр харилцан шүтэлцээ бүхий нийлбэрийг бүхэлд нь сонгуулийн тогтолцоо гэж үздэг. Уг тогтолцооны эхлэл нь төрийн эрх мэдэл, иргэдийн сонгох, сонгогдох эрх бөгөөд түүнийг хангах, хамгаалах, тохируулах **эрх зүйн хэм хэмжээ**, ойлгож баримтлах, мөрдөх ухамсар, хэрэглэх практикийг **сонгуулийн "эрх зүйн тогтолцоо"** гэнэ. Тогтолцоо тус бүртээ өргөн бүтэцтэй. Хууль тогтоогчдын хувьд "сонгуулийн эрхийн /сонгуулийн тогтолцооны/ үндсэн зарчим", "Санал тооцож, мандат хуваарилах аргын тогтолцоо"-г үл ялгах бөгөөд хооронд нь хольж хутгах нь бий.

¹ Б.Чимид. Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний Үндсэн хууль буруутай юу? Үндсэн хуульт ёсны төлөвшил цувралын IY боть, УБ 2011, 27 дахь тал

Угтаа сонгууль нь шууд ардчиллын гол хэлбэр бөгөөд сонгуулийн аль ч тогтолцооны үед сонгогчдын оролцоог шууд хангах зорилгоо биелүүлэх учиртай. Иймд иргэдийн оролцоо бол сонгуулийн эрх зүй, тогтолцооны үр дүнгийн гол шалгуур юм. Өөрөөр хэлбэл, **иргэдийн оролцоо нь сонгуулийн эрх зүй, тогтолцооны үр дүнгийн гол шалгуур мөн**. Сонгох аргын тогтолцоог дур зоргоор, үндэслэлгүй өөрчлөх нь сонгуулийн легитим чанарыг алдагдуулж, улмаар иргэдийн ардчилалд итгэх итгэлийг үгүй хийх эрсдэл дагуулна.

Дэлхийн нийтэд сонгуулийн тогтолцооны мажоритар буюу олонхиор тооцох, пропорциональ буюу хувь тэнцүүлэх, эсхүл мажоритар, пропорциональ хосолсон гэсэн гурван үндсэн аргыг хэрэглэдэг. Холимог тогтолцоог ихэнхдээ газар нутаг том, хүн ам олонтой, олон үндэстэн ястан оршин суудаг, бүс нутгийн болон үндэсний эрх ашгийг төлөөлөх зайлшгүй шаардлагатай улсуудад сонгосон байдаг². Энэ тогтолцоог холимог хувь тэнцүүлсэн, зэрэгцээ (параллель) гэж ангилна.

Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоонд сонгогчдын өгсөн нэг саналаар 2 өөр тогтолцооны суудал хуваарилах аргыг хэрэглэдэг бол зэрэгцээ (параллель) тогтолцооны саналын арга нь сонгогч олонхийг төлөөлөх хэсэгт 1 санал, хувь тэнцүүлэн хуваарилах хэсэгт 1 санал өгдгөөрөө ялгаатай. Сонгуулийн бүх тогтолцоо практикт ямар үр дүнд хүргэх нь тогтолцоог хэрхэн хуульчилснаар буюу нарийвчилсан зохицуулалтыг хэрхэн тусгаснаар хамаардаг. Монгол Улсын хувьд УИХ-ын 2012 оны ээлжит сонгуульд холимог тогтолцооны зэрэгцээ (параллель) хувилбарыг хэрэглэсэн түүх бий.



СОНГУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ТОГТОЛЦООНЫ ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ

Сонгуулийн тогтолцоо буюу санал хураах тогтолцоо гэдэг нь сонгогч тодорхой хувилбаруудаас өөрийн сонголтыг хийхтэй холбогдсон харилцаа юм. Энэ нь санал хураах, санал тоолох, эцсийн дүнг нэгтгэн тооцох дүрэм журмыг өөртөө агуулж байдаг. Сонгуулийн тогтолцоог судалдаг онолыг сонгуулийн эрх зүй гэж хэлбэр талаас тодорхойлж болох бөгөөд түүний цаана улс төр судлал, эдийн засаг, математикийн агуулга оршиж байдаг.

Сонгуулийн тогтолцоог өргөн хүрээнд, хязгаарлагдмал хүрээнд гэсэн хоёр түвшинд авч үзэж агуулгыг нь тодорхойлдог.

- Иргэнд сонгуулийн эрхийг нээж өгөх, сонгуулийн эрхийн зарчмыг тодорхойлох, төрийн төв болон

орон нутгийн сонгуулийг зохион байгуулж явуулах, сонгуулийн санал хураалтын дүнг нэгтгэж, үр дүнг тодорхойлох зэрэг харилцааг зохицуулж байгаа эрх зүйн хэм хэмжээг бүхэлд нь сонгуулийн тогтолцооны өргөн хүрээний тодорхойлолт гэж үздэг. Ийм эрх зүйн системийг бүхэлд нь сонгуулийн эрх зүй гэдэг.

- Санал хураалтын дүнг нэгтгэн тодорхойлох журмыг сонгуулийн тогтолцооны хязгаарлагдмал хүрээний тодорхойлолт гэж үздэг.

1936 оны ЗСБНХУ-ын Үндсэн хуульд сонгуулийн тогтолцоог өргөн утгаар нь тодорхойлох хүртэл гадаад орнуудын судлаачид сонгуулийн тогтолцоог хязгаарлагдмал хүрээнд тодорхойлсоор иржээ.

Сонгуулийн саналын агуулга, тойргийн хэмжээ, санал хураалтын дүнг мандатад шилжүүлэн тооцох журам, саналаа тухайлсан нэр дэвшигчийн төлөө, эсвэл түүнийг хамруулж байгаа нам, эвсэл/нэрсийн жагсаалт/-ийн төлөө өгөх зэрэг хувьсах чанартай үзүүлэлтүүдийг харгалзан сонгуулийн тогтолцоог дор дурдсанаар ангилдаг.

СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООНЫ АНГИЛАЛ:

Дэлхийн улсуудад сонгуулийн тогтолцооны маш олон хувилбар үйлчилж байгаа бөгөөд тэдгээр нь дотроо олон хувилбартай байгаа юм. Үүнийг хялбарчлан сонгуулийн олонхийг төлөөлөх тогтолцоо, сонгуулийн хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо, сонгуулийн холимог тогтолцоо гэсэн гурван ангилалд авч үздэг. Эдгээрийн алинд ч хамааруулж болохооргүй үл шилжих нэг саналын, хязгаарлагдмал саналын, саналыг дугаарлаж өгөх Бордогийн тооцооны арга гэсэн сонгуулийн тогтолцооны ангилал бас бий.

Олонхийг төлөөлөх (мажоритар) тогтолцоо: Тодорхой нэр дэвшигчээр дамжуулан сонгуулиар байгуулагддаг эрх барих байгууллагыг бүрдүүлдэг тогтолцоог олонхийг төлөөлөх тогтолцоо гэнэ. Олонхийг төлөөлөх тогтолцоо нь харьцангуй олонхийн, багц саналын, намын багц саналын, дараалал тогтоож саналаа өгөх алтернатив саналын, хоёр шатлалтай саналын гэх мэт хувилбаруудтай. Сонгогчдын олонхийн санал авсан нэр дэвшигч сонгогдсонд тооцогдох бөгөөд туйлын олонх (50+1), харьцангуй олонх /хамгийн олон санал авсан/, дийлэнх (2/3) болон үнэмлэхүй олонх (3/4)-ийн саналаар сонгогдох гэж ангилдаг.

Мажоритар буюу олонхийн тогтолцоо бол Монгол Улсад өнөөг хүртэл хэрэглэж ирсэн хувилбар буюу төрөл зүйл нь бөгөөд олонхийн саналаар нэр дэвшигчийг сонгогдсонд тооцдог арга юм.

Олонхийн тогтолцооны нэн зохистой, итгэмжтэй хувилбар нь ердийн олонх буюу 50 хувиас дээш саналаар

² Сонгуулийн холимог тогтолцоот улсуудын сонгогчдын санал гаргах хувилбарууд, СТ-11/228. УБ 2011 он, 2 дахь тал.

сонгогдсонд тооцох явдал юм.³

Энэхүү тогтолцоо нь:

- сонгогчдод илүү тод, ойлгомжтой;
- хүнд төвлөрөн өрсөлддөг;
- хүчтэй том намуудад илүү ашигтай;
- Иймээс хоёр (том) намын тогтолцоо руу хөтөлдөг;
- Парламент ба Засгийн газрын уялдааг илүү хангадаг.

Тухайлбал, олонх Засгийн газраа "хамгаалагч"-ийн үүрэг гүйцэтгэдэг зэрэг эерэг талтай. Харин эерэг талыг урвуулан ашиглавал тэр нь сөрөг болон хувирдаг сул талтай. Жишээлбэл, олонх Засгийн газраа ямар ч ноцтой алдаа хийсэн хуурмагаар өмгөөлөн хамгаалах явдал үзэгддэг байна.

Олонхийн тогтолцоо⁴

Сонгуулийн мажоритар буюу олонхийн тогтолцооны зарчим нь маш энгийн байдаг. Сонгогчид саналаа өгсний дараа сонгогчдын өгсөн саналыг тоолж, хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг ялагчаар тодруулдаг. Харин практикт олонхийн тогтолцоогоор ялагчийг тодруулах хэд хэдэн хувилбар бий. Олонхийн системийн үндсэн хувилбарт

1. нэг мандаттай тойргийн систем (First past the post or Single member district system)
2. томсгосон тойрог (Block vote)
3. альтернатив саналын систем (Alternative vote)
4. хоёр шаттай тогтолцоо (Two-round system)⁵ орно.

ХУВЬ ТЭНЦҮҮЛЭН ХУВААРИЛАХ ТОГТОЛЦОО:

Нам, эвслийн төлөөллөөр дамжуулан сонгуулиар байгуулагддаг эрх барих байгууллагыг бүрдүүлдэг тогтолцоог хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо гэнэ. Нам эвслийн авсан саналын хувьтай мандатын тоо нь уялдаж байх ёстой. Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоо нь жагсаалт (нээлттэй ба хаалттай)-ын, шилжих бололцоотой нэг саналын гэх мэт олон хувилбартай. Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоонд:

- Нам, эвслүүдэд суудал хуваарилах тооцоо нь давуу тал олонтаа ч зарим талаар хүндрэлтэй.
- Ихэнх тохиолдолд сонгуулийн босго тогтоох замаар суудлыг хуваарилдаг.
- Сонгуулийн босгыг ихэнхдээ тухайн тойрог/улсын хэмжээнд/-ийн сонгуулийн хүчинтэй саналын тоог мандатын тоонд харьцуулж тодорхойлдог.

- Намын нэрийн жагсаалтаас хэдэн хүнд мандат хуваарилагдах вэ гэдэг нь босго саналын тоо тухайн намын авсан саналын тоонд хэд дахин багтаж байгаагаар илэрхийлэгдэнэ.
- Үлдэгдэл саналыг хэрхэн хуваарилах нь хамгийн том асуудал.

СОНГУУЛИЙН ХОЛИМОГ ТОГТОЛЦОО:

Олонхийг төлөөлөх, хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцооны аль, алиных нь шинжийг агуулдаг. Энэхүү тогтолцоог холимог хувь тэнцүүлсэн, зэрэгцээ (параллель) гэж ангилж болно. Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоонд сонгогчдын өгсөн нэг саналаар хоёр өөр тогтолцооны суудал хуваарилах аргыг хэрэглэдгээрээ онцлог юм. Зэрэгцээ (параллель) саналын арга нь сонгогч олонхийг төлөөлөх хэсэгт 1 санал, хувь тэнцүүлэн хуваарилах хэсэгт нэг санал өгдгөөрөө ялгаатай.

Сонгуулийн янз бүрийн тогтолцооны эцсийн үр дүн нь олон янз байж болох бөгөөд ялангуяа илэрхий олонх байхгүй тохиолдолд бүр илүү мэдрэгддэг. Иймээс сонгуулийн тогтолцоог сонгохдоо хэлбэр талаас нь биш, агуулгаар нь авч үзэхийг онолын талаас шаардах болжээ. Сонгуулийн тогтолцооны агуулгад дор дурдсан хүчин зүйлсийг зайлшгүй тооцох хэрэгтэй байдаг. Үүнд:

1. Сонгуулийн тогтолцооны агуулгад:
 - Саналаа илэрхийлэх хэлбэр;
 - Нэр дэвшигчийн асуудал;
 - Санал адил жинтэй байх шаардлага;
 - Саналын босго тогтоох арга;
 - Сонгуулийн тойрог, сонгогчид хамаарах үндэсний болон хүйсийн онцлогийг тооцож үзэх шаардлага.
2. Олон ялагч тодруулах арга:
 - Хувь тэнцүүлэн хуваарилах арга;
 - Хагас хувь тэнцүүлэх арга;
 - Холимог тогтолцооны арга.
3. Ганц ялагчийг тодруулах арга:
 - Нэг болон дараалалд оруулсан саналын арга;
 - Шилдгийг тодруулах олон шатлалтай саналын арга;
 - Зэрэглэх саналын арга /саналаа дугаарлаж өгөх, хэлэлцүүлэгтэй санал өгөх/;
 - Нэг ялагчийг шалгаруулах үнэлгээний шалгуур зэргийг харгалзан үзэх хэрэгтэй.

³ Мөн тэнд, 57 дахь тал.

⁴ Д.Гангабаатар., Үндсэн хуулийн эрх зүй, УБ хот, 2019 он, 198 дахь тал.

⁵ Benoit, Duverger's law and the study of Electoral systems.



СОНГУУЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛИЙН НӨЛӨӨ

Сонгуулийн тогтолцооны нөлөөлөл			Сонгогч саналаа гаргах чиглэлийн нөлөөлөл			
Олонхийг төлөөлөх Хувь тэнцүүлэн	Хувь тэнцүүлэн хуваарилах	Холимог	Намын нэрийн жагсаалтад	Нэр дэвшигчийн нэрийн жагсаалтад	Тухайлсан нэр дэвшигчид	
					Олонхийг төлөөлөх тогтолцооны	Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцооны
ДАВУУ ТАЛ						
Том намуудад давуу тал үүсгэдэг. Төрийн эрхийг том намууд тогтвортой барих нөхцөл бүрдүүлнэ.	Парламент олон нам суудал авах нөхцөл бүрдүүлнэ. Аливаа үзэл бодол, үнэт зүйл нэг танхимд хэлэлцэгдэх боломж бүрдүүлнэ.	Олонхийг төлөөлөх, хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцооны давуу талуудыг товойлгох, дутагдалтай талуудыг хязгаарлах бололцоо бүрдүүлнэ. Том улсуудад болон үндэсний асуудал тавигддаг улсуудад тохиромжтой.	Жижиг намуудад суудал ногдох боломжийг илүү бүрдүүлнэ. Хувь тэнцүүлсэн шинж улам тодрох, санал адил жинтэй байх, санал өгөх, тооцоход хялбар, хүйсийн тэгш байдал, үндэстний асуудлыг шийдвэрлэх нөхцөл бүрдүүлнэ.	Намын нээлттэй нэрийн жагсаалт байдгаараа сонгогчид илүү ойлгомжтой. Жижиг намуудад суудал ногдох боломж давуу.	Цөөн намын нөлөөг нэмэгдүүлж, олонхийн Засгийн газар бүрдэж, хариуцлага, нэг хүчинд төвлөрнө.	Парламентад хэд хэдэн нам орж, ялангуяа жижиг нам суудал авах магадлал өснө. Намын доторх нэр дэвшигчдийн сонгогдох дараалалд сонгогч нөлөөлөх боломж бүрдүүлнэ.
ДУТАГДАЛТАЙ ТАЛ						
Сонгогчдын саналын багагүй хэсэг парламентад тусгалаа олохгүй байх сул талтай.	Засгийн газраа намууд нэгдэж байгуулах, хариуцлага хүлээх эзэн тодорхойгүй болох, Засгийн газар огцрох магадлал өснө.	Бүс нутгийн болон үндэсний хэмжээний асуудлын зааг ялгарч, Парламентад өөр, өөр ашиг сонирхол зөрчилдөх магадлалтай.	Орон нутаг, парламентын гишүүдийн амьд холбоо сулрах, намын лидерүүдийн давамгайл байдал тогтох, эсвэл нөлөө багатай, үгнээс гардаггүй хүмүүсийг жагсаалтдаа оруулах, намын доторх эрүүл санал, бодлыг үл хүндэтгэх талтай.	Парламент олон намын оролцоотой болж, намууд хамтарч Засгийн газрыг бүрдүүлэх тохиолдол элбэг байдаг.	Сонгогчийн өгсөн саналын нэлээд хэсэг нь парламентад тусгалаа олохгүй гадна талд нь үлддэг.	Намын нээлттэй нэрсийн жагсаалтаас сонголт хийх сонгуульд оролцож байгаа нам бүрээр нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалт гаргаж, сонгогч бүр түүнээс сонголт хийхэд төвөгтэй.



СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО УЛС ОРНЫ ХӨГЖИЛД ХЭРХЭН НӨЛӨӨЛДӨГ ВЭ? МОНГОЛЧУУДАД ХОЛИМОГ ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОХЫН УЧИР (Дэлхийн улс орнууд дахь сонгуулийн тогтолцоо)

Ардчилал, сонгуульд туслах олон улсын хүрээлэн (IDEA)-гээс иш татан үзвэл өдгөө дэлхийн 219 улсаас 32 нь сонгуулийн холимог, 65 нь олонхийг төлөөлөх, 77 нь хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоотой, 7 нь шууд сонгууль явуулдаггүй, 5 нь тодорхой мэдээлэлгүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Сонгуулийн тогтолцоо	Улсын тоо, эзлэх хувь	Сонгуулийн тогтолцооны хувилбар	Улсын тоо, сонгуулийн хувилбарт эзлэх хувь	Улсын нэр
Сонгуулийн холимог тогтолцоотой	32 улс (16.7%)	Холимог хувь тэнцүүлсэн	8 улс	Жибути, ХБНГУ, Унгар, Мексик, Шинэ Зеланд, БНСУ, Тажикистан, Тайланд
		Зэрэгцээ	18 улс	Андорра, Конго, Египет, Гүрж, Итали, Япон, Йордан, Литва, Мавритани, Нижер, Умард Македон, Панам, Филиппин, ОХУ, Сенегал, Сейшелийн арлууд, Украин, Венесуэл
		Мэдээлэл байхгүй	6 улс	Боливи, Гайана, Лесото, Ливи, Мадагаскар, Непал
Олонхийг төлөөлөх тогтолцоотой	65 улс (34.8%)	Алтернатив саналын	2 улс	Австрали, Папуа Шинэ Гвиней
		Багц саналын	2 улс	Этиоп, Монгол
		Харьцангуй олонхийн	47 улс	Бахам, Бангладеш, Барбадос, Белиз, Бутан, Ботсвана, Канад, Габон, Гамби, Гана, Гренада, Энэтхэг, Ямайка, Кени, Кирибати, Лаос, Либер, Малайз, Мальдив, Маршаллын арлууд, Маврики, Мьянмар, Науру, Нигери, Пакистан, Палау, Катар, Сент Китс ба Невис, Сент Люсия, Сент Винсент ба Гренадин, Самоа, Сьерра Леон, Сингапур, Соломоны арлууд, Тонга, Тринидад ба Тобаго, Туркменистан, Тувалу, Уганда, ИБУИНХУ, Танзани, АНУ, Йемен, Замби, Зимбабве
		Хоёр шатлалтай саналын	12 улс	Бахрейн, Беларусь, БНАСАУ, Вьетнам, Гаити, Иран, Төв Африкийн БНУ, Коморос, Конго, Эсватини, Франц, Узбекистан
		Мэдээлэл байхгүй.	2 улс	Кот д'Ивуар, Микронез

Хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцоотой	77 улс (41.1%)	Жагсаалтын	74 улс	Албани, Алжир, Ангол, Аргентин, Армени, Австри, Бельги, Бенин, Босни-Херцеговин, Бразил, Болгар, Бурунди, Кабо Верде, Камбож, Камерун, Чили, Колумби, Коста Рика, Хорват, Кипр, Чех, Дани, Доминика, Доминиканы БНУ, Эквадор, Эль Сальвадор, Экваторын Гвиней, Эстони, Фижи, Финланд, Грек, Гватемала, Гвиней-Бисау, Хондурас, Исланд, Индонез, Израил, Казахстан, Киргиз, Латви, Ливан, Лихтенштайн, Люксембург, Монако, Монтенегро, Марокко, Мозамбик, Намиби, Нидерланд, Никарагуа, Норвег, Парагвай, Перу, Польш, Португал, Румын, Руанда, Сан Марино, Сан Томе ба Принсип, Серби, Словак, Словени, Өмнөд Африк, Испани, Шри Ланка, Суринам, Швед, Швейцар, Зүүн Тимор, Того, Тунис, Турк, Уругвай, Вануату
		Шилжих бололцоотой нэг саналын	2 улс	Ирланд, Мальта
		Мэдээлэл байхгүй	1 улс	Молдова
Бусад	6 улс (3.2%)	Харьцангуй олонхын болон багц саналын	1 улс	Малави
		Үл шилжих нэг санал	5 улс	Афганистан, Куба, Ирак, Кувейт, Оман
Шууд сонгууль явуулдаггүй	7 улс (3.7%)	-	-	Бруней, БНХАУ, Эритрей, Саудын Араб, Сомали, Өмнөд Судан, АНЭУ
Мэдээлэл байхгүй	5 улс (3.0%)	-	-	Буркина Фасо, Чад, Гвиней, Мали, Сири



СОНГУУЛИЙН ХОЛИМОГ ТОГТОЛЦООНЫ ФОРМАЛЬ ШААРДЛАГА

Олон улсын экспертүүд **“Монголд тохирсон сонгуулийн систем бол хосолмол буюу холимог систем юм. Зөвхөн холимог систем л төлөөлөл, төвлөрөл, оролцооны хоорондоо харилцан уялдаа бүхий төрөл бүрийн шаардлагыг хамгийн сайнаар биелүүлж чадна”** гэж зөвлөдөг. Мөн манай улсын сонгогчид аль нэг намд бус хувь хүний төлөө саналаа өгөхийг хүсдэг. Үүний зэрэгцээ Монгол улс хүн ам цөөтэй, нийгэмд хувь хүмүүсийн холбоо чухал үүрэг гүйцэтгэдэг. Иймээс хатуу жагсаалт

бүхий пропорциональ сонгууль хууль ёсны байх үүргээ гүйцэтгэж чадахгүйд хүрнэ гэж үздэг байна.

Үндсэн хуулийн шууд сонгох зарчим нь сонгогч нэр дэвшигчид шууд саналаа өгөх сонгуулийн системтэй байхыг хуульчилсан гэдэг нотолгоотой дүйнэ. Гэхдээ шууд сонгууль гэдгийг хүнээ шууд сонгох бус “Ямар нэгэн төлөөлөх байгууллагагүйгээр Их Хурлыг бүрдүүлнэ гэсэн ерөнхий зарчим” гэж тайлбарлах хуульчид байдаг. Тэдний үзэж буйгаар намд санал өгөх замаар Их хурлаа байгуулах, хүн сонгох замаар Их хурлаа байгуулах энэ хоёрын зохистой хувилбарыг юм уу, эсхүл манай нөхцөлд хосолсон хувилбараар байж болно болох бөгөөд чадвартай Парламент, хариуцлагатай Засгийн газрын үндсэн зарчим хэрэгжинэ гэж үздэг.

Дэлхийн улс орнуудын хувьд, Олон улсын парламентын

6 Диетер Ноолен. ХБНГУ-ын Хайдельбергийн Их сургуулийн доктор, профессор

7 Б.Чимэд. “Сонгуулийн үндсэн зарчим, түүнийг сонгуулийн хуулиар баталгаажуулахуй”, 2002. УБ

холбоо (IPU)-ны гишүүн дэлхийн 1912 улсаас парламентын засаглалтай 74 улс, ерөнхийлөгчийн засаглалтай 46 улс, холимог засаглалтай (Presidential-parliamentary) 45 улс, хаант засаглалтай 12 улс, коммунист систем (Communist system)-тэй 5 улс байна. Эдгээрээс парламентын засаглалтай 74 улсын 43 нь нэг танхимтай, 31 нь хоёр танхимтай байна⁸. Сонгуулийн холимог тогтолцоо нь олонхийг төлөөлөх /мажоритар/, хувь тэнцүүлэн хуваарилах тогтолцооны аль алиных нь шинжийг агуулдаг бөгөөд энэхүү тогтолцоог дэлхийн 30 гаруй орнууд ашигладаг.

Ер нь холимог тогтолцоог ихэнх тохиолдолд газар нутгийн хэмжээ томтой, олон хүн амтай, олон үндэстэн ястан оршин суудаг, бүс нутгийн болон үндэсний эрх ашгийг төлөөлөх зайлшгүй шаардлагатай улс орнууд сонгосон байдаг⁹. **Монгол Улс өргөн уудам нутаг дэвсгэртэй, хүн ам цөөтэй учир энэхүү тогтолцоог хэрэгжүүлэх боломжтой.**

Холимог тогтолцоо нь холимог хувь тэнцүүлсэн, зэрэгцээ (параллель) гэсэн хувилбартай. Холимог хувь тэнцүүлсэн тогтолцоонд сонгогчдын өгсөн нэг саналаар 2 өөр тогтолцооны суудал хуваарилах аргыг хэрэглэдэг бол зэрэгцээ (параллель) тогтолцооны саналын арга нь сонгогч олонхийг төлөөлөх хэсэгт 1 санал, хувь тэнцүүлэн хуваарилах хэсэгт 1 санал өгдгөөрөө ялгаатай.

Параллель уу, холимог хувь тэнцүүлсэн тогтолцоо юу гэдгийг тодорхойлох хүчин зүйлсийг дэлхийн улсууд судалж, туршлага мэдлэг хуримтлуулсаар ирсэн байдаг. Энэ тогтолцоонд мажоритар болон хувь тэнцүүлсэн тогтолцоогоор хуваарилах суудлын харьцаа, хувь тэнцүүлэх тогтолцооны тойргуудын хэмжээ, түвшин, хувь тэнцүүлсэн зарчмаар жагсаалтаас сонгогдох шалгуур, саналын хуудасны тоо, намын жагсаалтаар санал хураах хувь тэнцүүлсэн тогтолцооны суудал хуваарилах арга, хувь тэнцүүлсэн тогтолцоонд намын нээлттэй болон хаалттай жагсаалтаар санал хураах сонголт, парламентын суудал хуваарилахад оролцох саналын босго, гадаадад байгаа иргэд санал өгөх¹⁰ зэрэг хүчин зүйлс чухал нөлөөтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулахаар ард нийтийн зөвлөлдөх санал асуулга явуулж байгаа энэ цаг мөчид сонгуулийн хуульд өөрчлөлт оруулах, сонгуулийн тогтолцоог сонгох дээр маргаантай байгаа энэ үед харьцуулсан дүн шинжилгээ хийх шаардлага амьдралаас урган гарсныг эцэст нь хэлэх нь зүйтэй.

НОМ ЗҮЙ

Эрх зүйн акт:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль

Ном:

- Гадаадын зарим улсын Үндсэн хуулийн улс төрийн намын талаарх зохицуулалт ба намын санхүүжилт” СТ-18/206. ПСХ. 2018 он)
- Шинжлэх ухаан технологийн их сургууль, Улс төр судлал УБ. 2011
- Монгол Улсын Үндсэн хууль, “Төрийн мэдээлэл” сэтгүүл 1992 он №1
- Б.Нармандах, Үндсэн хуулийн эрх зүй, УБ, 2017
- Б.Чимид. Сонгуульд суралцахуй. Тогтолцоо, үйл явц, эрх зүй, 2008
- Б.Чимид. Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний Үндсэн хууль буруутай юу. Үндсэн хуульт ёсны төлөвшил цуврал IV, 2011
- Нээлттэй нийгэм форум. Сонгуулийн бүтэц, зохион байгуулалт, УБ, 2010
- Улс төрийн намын үзэл баримтлал, дэлхий нийтийн чиг хандлага, улс төрийн нам байгуулах босго, гишүүнчлэл болон сонгуулийн пропорциональ систем: Олон Улсын туршлага Лавлагаа мэдээлэл. 2022
- Парламентын сонгуулийн тогтолцоо, парламентын гишүүдийн тоо ба түүнийг тогтоох, тооцох зарчим, 2022
- “Сонгуулийн боловсрол” сэтгүүл, дугаар 2023/01
- Сонгуулийн холимог тогтолцоо, онол практик. 2023

Судалгааны тайлан:

- Парламентын нэг танхимтай улсуудын хүн амын тоог парламентын гишүүдийн тоонд харьцуулсан байдал СТ-19/417 Р.Оргилмаа 29 боть
- Хоёр шатлал бүхий нэг танхимтай парламент:БНХАУ, Вьетнам Улсын туршлага СТ-17/211 Ц.Болормаа 25 боть

8 “Дэлхийн хууль тогтоох байгууллагын бүтэц” тойм судалгаа СТ-22/304. 5 дахь тал


9 Сонгуулийн холимог тогтолцоог улс орнуудын сонгогчдын санал гаргах хувилбарууд СТ-11/228. УБ 2011 он 2 дахь тал.

10 “Сонгуулийн холимог тогтолцооны онол, практик” номд дэлгэрэнгүй тайлбарласан байна.

- Сонгуулийн хувь тэнцүүлэн хуваарилах болон холимог тогтолцоо бүхий орнуудын намаас нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах тухай СТ-16/406 22 боть
- Сонгуулийн холимог тогтолцоот улс орнуудын сонгогчдын санал гаргах хувилбарууд СТ-11/228 12 боть
- Ц.Товуусүрэн, Р.Хатанбаатар, А.Пагма, Ц.Болормаа Зарим улс орнууд дахь сонгуулийн холимог тогтолцооны эрх зүйн зохицуулалт СТ-11/423
- Ц.Болормаа.Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг ард нийтийн санал асуулгаар баталсны дараа албажуулах, хэвлэн нийтлэх, хүчин төгөлдөрт тооцох процесстой холбоотой гадаадын зарим орны эрх зүйн зохицуулалт СТ-18/214
- Ц.Болормаа.Хоёр шатлал бүхий нэг танхимтай парламент: БНХАУ, Вьетнам Улсын туршлага СТ-17/211
- О.Нарантуяа. Дэлхийн улс орнуудын хууль тогтоох байгууллагын бүтэц СТ-22/304
- Р.Оргилмаа. Дэлхийн улс орнуудын хууль тогтоох байгууллагын бүрэлдэхүүн СТ-22/305
- Д.Халиун. Дэлхийн улс орнуудын хууль тогтоох дээд байгууллагын сонгуулийн тогтолцоо СТ-22/306
- Г.Билгээ, Д.Халиун Парламентын сонгуулийн тогтолцоо, парламентын гишүүдийн тоо ба түүнийг тогтоох, тооцох зарчим СТ-22/405 40 боть
- Ч.Базар, А.Пагма.Сонгуулийн системийн харьцуулалт: Давуу ба сул тал СТ- 09/219
- Дэлхийн улсуудын төрийн удирдлагын хэлбэр. Парламентын засагтай орнуудын сонгуулийн зарчим харьцуулсан судалгаа. 2015
- Дэлхийн улс орнуудын хууль тогтоох дээд байгууллагын сонгуулийн тогтолцоо, тойм судалгаа, 2022, УИХ-ын Тамгын газар.







05

ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн онцлог зохицуулалтууд /2023 он/

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

33



УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ - ОНЦЛОГ ЗОХИЦУУЛАЛТ

2023 он



ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Улсын Их Хурлын үйл ажиллагааны практикаас үзэхэд УИХ-ын гишүүд улс орны хөгжил, бодлогын асуудлаас илүүтэйгээр сонгогдсон тойрогтоо илүү хамааралтай байр сууринаас бодлого, шийдвэрт хандах нь давамгайлах болсон.

Үүнээс шалтгаалан үндэсний хэмжээний бодлого тодорхойлох, томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд хүндрэлүүд үүссээр байна.

Иймд нэг талаар сонгуулийн тогтолцоог үндэсний нийтлэг сонирхлыг хангаж чадахуйц хэлбэрээр шинэчлэх, нөгөө талаар УИХ-ын бодлого тодорхойлох бүтэц үүсээд байхад үйл ажиллагааны агуулгыг боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатай гэж үзсэн.

УИХ-ын сонгуулийн тухай хуулийн төсөлд тусгагдсан зарим онцлог зохицуулалтыг танилцуулж байна.

ОНЦЛОГ ЗОХИЦУУЛАЛТУУД

1

СОНГУУЛИЙН ХОСОЛСОН ТОГТОЛЦООТОЙ БАЙХ


- Тойргоос 38, жагсаалтаас 38
- жагсаалтад болон тойрогт давхар нэр дэвшихгүй.
- тойргийн нийт мандатын 50 хувьд нэр дэвшүүлсэн байх
- нам -3% босго
- 2 нам бүхий эвсэл 5%
- 3 болон түүнээс дээш нам бүхий эвсэл 7%



2

НЭР ДЭВШҮҮЛЭХ АЖИЛЛАГАА

- 30%-аас доошгүй аль нэг хүйсийн төлөөлөл
- Жагсаалтад 1:1 хүйсийн харьцааны дарааллыг үндэслэнэ.



3

ГАДААД УЛСАД БАЙГАА ИРГЭДЭЭС САНАЛ АВАХ

- Гадаадад санал авах өдөр 4 хоног.
- Нам, эвсэл түүнээс жагсаалтаар нэр дэвшигчид санал өгөх.
- ДДГазар байрладаггүй газарт салбар комисс байгуулах.
- Сонгогчийн бүртгэлийн олон шат дамжлага байхгүй.



4

УРЬДЧИЛАН САНАЛ АВАХ АЖИЛЛАГАА

- Санал авах өдөр өөрийн биеээр санал авах байранд очиж чадахгүй сонгогч
- Санал авах өдрийг хүртэлх 5 хоногийн хугацаанд
- 09:00–17:00 хооронд өөрийн харьяа санал авах байранд



5

СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ


- Сонгогч сонгогчдын нэрийн жагсаалт дахь өөрийн болон **өөрийн байнга оршин суугаа хаягийн бүртгэлд бүртгэгдсэн нийт сонгогчийн** мэдээлэлтэй танилцах
- Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн нам, эсвэл, бие даан нэр дэвшигч, төрийн бус байгууллага нь **санал хураалтын өмнө болон дараа** сонгогчдын нэрийн жагсаалт, түүнийг үйлдэх үйл ажиллагаатай холбогдох журмын дагуу танилцах эрхтэй.



6

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА, ЗАРДАЛ

- Сурталчилгаа 17 хоног
- Ухуулагч 30% буурна.
/нийслэл болон аймгийн төвд 400 сонгогч тутамд нэг ухуулагч, бусад газарт 200 хүртэлх сонгогч тутамд нэг ухуулагчтай байж болно. Ухуулагч нь сайн дурын үндсэн дээр ажиллах бөгөөд урамшууллын хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хэтрэхгүй. /
- Тээврийн хэрэгсэл 50% буурна
/нэг хэсэгт ~~дөрвөөс~~ хоёроос илүүгүй тээврийн хэрэгсэл ашиглаж болно./
- Хэвлэмэл материал 30% буурна.
 1. ~~гурван~~ хоёр хэвлэлийн хуудас сонин;
 2. ~~гурван~~ хоёр хэвлэлийн хуудас сэтгүүл;
 3. нэг хэвлэлийн хуудас ухуулах хуудас.
- Ухуулах хуудас 50% буурна
/нэг хэсэгт ~~20-өөс~~ 10-аас илүүгүй байршуулна./
- Сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материалыг бүхэлд нь **брайль үсэгтэйгээр** хэвлүүлж болно. Брайль үсэг бүхий хэвлэмэл материал нь хуульд заасан хэмжээнд хамаарахгүй.
- Жагсаалтаар нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааг намын сонгууль эрхэлсэн байгууллага хариуцах бөгөөд сурталчилгааны хэвлэмэл материал нь гурван хэвлэлийн хуудас хэмжээнээс хэтрэхгүй байна.
- Зурагт самбар 70% буурна.
- Радио, телевиз ашиглах /ОНРТелевиз сурталчилгааны болон мэтгэлцээний нэвтрүүлгийг төлбөргүй нэвтрүүлнэ. **Сонгуулийн сурталчилгааны болон мэтгэлцээний хуваарь, цагийг тэнцүү хэмжээнд тогтооно./**
- Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулахад зарцуулах зардал нь сонгуульд зарцуулсан **нийт зардлын 15 хувиас хэтрэхийг хориглоно.**



7

САНАЛЫН ХУУДАС, САНАЛ ТЭМДЭГЛЭХ

- Саналын хуудас нь:
 1. Тойрогт нэр дэвшигчийн санал тэмдэглэх.
 2. Нам, эвсэл тэдгээрээс жагсаалтаар нэр дэвшигчийн саналыг тэмдэглэх хэсэгтэй байна.
- Нам, эвсэл тэдгээрээс жагсаалтаар нэр дэвшигчийн саналыг тэмдэглэх хэсэгт 1 нам, эвсэлд эсхүл жагсаалтаар нэр дэвшигчээс 1 нэр дэвшигчид саналаа өгнө.
- Нам, эвслээс жагсаалтаар нэр дэвшигчид өгсөн саналыг тухайн нам, эвсэлд өгсөн саналд тооцно.







06

ЦАХИМ СИСТЕМ

- “Сонгуулийн мэдээллийн нэгдсэн сан”
цахим системийг (www.e-election.mn)
хөгжүүлж байна

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

37

“СОНГУУЛИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН” ЦАХИМ СИСТЕМИЙГ (WWW.E-ELECTION.MN) ХӨГЖҮҮЛЖ БАЙНА

Б.УУГАНЦЭЦЭГ

Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн Ахлах референт



Төрийн байгууллагууд үйл ажиллагаагаа цахимжуулж, эдгээр үйл ажиллагааг зохицуулсан салбарын хуулиуд шинээр батлагдсан нь төрийн үйлчилгээг түргэн шуурхай авах, хүнд сурталгүй авах, авлигаас ангид байх боломжийг бүрдүүлэх, цаг, хугацаа, төсвийн хувьд хэмнэлтийг бий болгох зэрэг олон давуу талыг үүсгэж байна. Энэ

хүрээнд Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос сонгуулийн үйл ажиллагааг цахимжуулж, ажлын бүтээмж, байгууллага хоорондын мэдээлэл солилцооны үр ашгийг нэмэгдүүлэх, олон нийтийг нээлттэй, ил тод мэдээллээр хангах, мэдээллийг нэгдсэн эх сурвалжаар түгээх, нээлттэй өгөгдлийг бий болгох зорилгоор “Сонгуулийн

мэдээллийн нэгдсэн сан” цахим системийг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Манай улс сонгуулийн сонгогчийг баталгаажуулах, санал авах тоолох, дүн гаргах, дамжуулах үйл ажиллагааг 2012 оноос хойш автоматжуулж, хүний оролцоогүйгээр саналын дүнгээ нэгтгэж ажилласаар өнөөг хүрсэн.

Энэ хугацаанд бид сонгуулийн саналын дүнг нэгтгэх үйл ажиллагааг дэлгэцээр шууд дамжуулах, санал авах байрны үйл ажиллагааг хяналтын камераар хянаж шууд дамжуулах, сонгуулийн ирцийн мэдээг нэгтгэх, шууд харуулах зэрэг сонгуулийн үйл ажиллагааг шат дараалан автоматжуулж, цахимжуулсан байна.

Төрийн байгууллагууд үйл ажиллагаагаа цахимжуулж, салбар бүр өөр, өөрийн цахим мэдээллийн санг бий болгож, төрд байгаа мэдээллийг байгууллагууд хоорондоо солилцох, "Хур" системээр дамжуулан иргэдэд үйлчлэх зохицуулалтыг 2022 онд шинээр батлагдсан цахимын тухай багц хуулиудад тусгасан нь чухал алхам болсон юм.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн 2022 оны нөхөн болон дахин сонгуулийг зохион байгуулах үеэр сонгуулийн үйл ажиллагаанд оролцогчдыг цахимаар бүртгэх оролдлогыг анхлан хийсэн. Гэвч Сонгуулийн ерөнхий хороонд байгууллагын хэмжээнд бий болгосон цахим системийг нэвтрүүлээгүй байсан учраас бид И-Монгол академитай хамтран нэр дэвшигчийг сонгуульд бүртгэх үйл ажиллагааг зохион байгуулсан.

Энэ ажлын явц болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд сонгууль зохион байгуулагдах үйл ажиллагааны явцад хуримтлагдсан мэдээллийг нэгтгэх, нээлттэй болгох, ашиглах боломжтой хэлбэрт оруулах, боловсруулдаг байх, сонгуульд оролцогчдын бүртгэлийг хялбараар шийдэх боломжийг бий болгох "Сонгуулийн мэдээллийн нэгдсэн сан" цахим системийг шинээр нэвтрүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, www.e-election.mn-ийг хөгжүүлж байна. Уг системээр сонгуулийн байгууллагад ажиллаж буй албан хаагчдын бүртгэл, сургалт, сонгуулийн хороодод

ажиллах албан хаагчдын хүсэлтийг авах, сонгуульд оролцогч нам эвсэл, нэр дэвшигчийг бүртгэх, нэр дэвшигчийн шадар туслагч, ухуулагч, ажиглагч, сурталчилгаанд ажиллах тээврийн хэрэгслийн бүртгэл болон сонгуулийн зардлын хуваарилалт, зарцуулалт, саналын дүн, ирц, сонгуулийн автоматжуулсан системийн санал тоолох төхөөрөмжийн бүртгэл, ашиглалтын талаарх мэдээлэл, төлөв, системийн хэрэглэгчдээс санал хүсэлт авах зэрэг дотоод зохион байгуулалттай холбоотой бүхий л ажиллагааг нэг системээр шийдэх боломжтой болж байна. Мөн "Сонгуулийн мэдээллийн нэгдсэн сан" цахим системд оруулсан бүх төрлийн мэдээллийг боловсруулж иргэд сонгогчид, судлаачдад боломжтой хэлбэрээр мэдээллийг гарган өгөх, ашиглах боломжийг бүрдүүлээ.

Системийн бүртгэл, мэдээлэл болон нэр дэвшигчийг бүртгэх хэсэгт төрийн бусад байгууллагаас үзүүлж буй төрийн мэдээлэл солилцооны

ХУР системд орсон бүх төрлийн лавлагааг авч болохоор зохицуулсан нь сонгуульд оролцогчдод бусад төрийн байгууллагаас авах лавлагаа мэдээллийг хүндрэл чирэгдэлгүйгээр нэг дороос шийдэж байгаа нь салбарын үйл ажиллагаанд хэрэгжүүлсэн чухал алхам юм.

Бид Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын 2023 оны нөхөн болон дахин сонгуулийг зохион байгуулах ажлын хүрээнд уг системийг ашиглан сонгуулийн байгууллагад ажиллах албан хаагчдыг сургаж, бүртгэж зарим аймаг, суманд нэр дэвшигчийг цахимаар бүртгэх ажлыг амжилттай зохион байгууллаа.

Энэ удаагийн системийн туршилт, ашиглалтад тулгуурлан системийн хөгжүүлэлтийг сайжруулж дараа дараагийн сонгуулийн үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах боломжийг бий болгохоор зорьж байна.





A blue geometric graphic consisting of several overlapping triangles and a large white number '07' in the center.

07

ХАРИУЦЛАГАТАЙ СОНГОГЧ БЭЛТГЭХ ХӨТӨЛБӨР

- “Хариуцлагатай сонгогч” хөтөлбөрийг орон даяар хэрэгжүүлж, 18-25 насныханд сонгуулийн боловсрол олгож байна

41

UIH.MN
СУДАЛГААНЫ САН


ХӨТӨЛБӨРИЙГ ОРОН
ДАЯАР ХЭРЭГЖҮҮЛЖ, 18-25
НАСНЫХАНД СОНГУУЛИЙН
БОЛОВСРОЛ ОЛГОЖ БАЙНА

Хөтөлбөрийн хүрээнд Сонгуулийн ерөнхий хорооны Мэдээлэл, судалгаа, сургалтын төвийн аймаг/дүүрэг хариуцсан сургагч багшаар 120 гаруй хүнийг бэлтгэн томилж, улмаар 2022, 2023 онд 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн 18-25 насны залууст сонгуулийн боловсрол олгох сургалтуудыг зохион байгууллаа.



“Хариуцлагатай сонгогч” бэлтгэх хөтөлбөрийн сургалтыг 2023 оны дөрөв, тавдугаар сард улсын хэмжээнд бүх аймаг, дүүрэгт явуулж, сонгуулийн тухай анхан шатны ойлголт, мэдлэг олгож, хууль, тогтоомж, хариуцлагатай сонгогчийн эрх, үүрэг, нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт дүн шинжилгээ хийх, хяналт тавих ур чадварт суралцах дадлага суулгахыг зорив. Сургалтад

ерөнхий боловсролын 11-12-р ангийн сурагчид, их, дээд сургууль, МСҮТ-үүдийн оюутнууд хамрагдаж, “Хариуцлагатай сонгогч”-ийн гэрчилгээ гардан авлаа. Сонгуулийн ерөнхий хороо энэхүү хөтөлбөрийг БНСУ-ын КОЙКА байгууллагын дэмжлэгээр НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран хэрэгжүүлж байгаа бөгөөд сургалт үргэлжилж байна.





УКРМ
СУДАЛГААНЫСАН



08

“СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛ” КЛУБЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

- “Сонгуулийн ирц, оролцоо”, “УИХ-ын хуулийн онцлог зохицуулалт: Сонгуулийн төв байгууллага ба Иргэний нийгмийн байр суурь” сэдвээр сургалт, хэлэлцүүлэг хийв.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

45



**“СОНГУУЛИЙН ИРЦ,
ОРОЛЦОО”,
“УИХ-ЫН ОНЦЛОГ
ЗОХИЦУУЛАЛТ:**


**Сонгуулийн төв
байгууллага ба иргэний
нийгмийн байр суурь”
сэдвээр сургалт,
хэлэлцүүлэг хийв**

Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх “Сонгуулийн боловсрол” сэтгүүлч, судлаачдын клубын уулзалтыг 2023 оны дөрөвдүгээр сарын 26-нд **“Сонгуулийн ирц, оролцоо”** сэдвээр “Сонгогчдын боловсролын төв” ТББ-тай, тавдугаар сарын 18-нд **“Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн онцлог зохицуулалт: сонгуулийн төв байгууллага ба иргэний нийгмийн байр суурь”** сэдвээр Нээлттэй нийгэм форумтай хамтран тус тус зохион байгууллаа. Сонгуулийн ирц, оролцоо нь дэлхий нийтэд, ялангуяа цар тахлын жилүүдэд сорилт болон хөндөгдөж буй асуудлын нэг тул сонгогчдын оролцоог нэмэгдүүлэх, сонгуулийн боловсролыг түгээн дэлгэрүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн хуулиар хүлээсэн үүргийг сануулах, хамтран ажиллах, энэ чиглэлд сэтгүүлчдийг мэргэшүүлэх, онолын судалгааг хөгжүүлэх нь зүйтэй гэж клубын гишүүд үзэв.

Харин УИХ-ын чуулганаар хэлэлцүүлж буй сонгуулийн хууль тогтоомжийн төсөлд шинээр тусгасан зүйл, заалт тус бүрээр Сонгуулийн ерөнхий хорооны Хуулийн хэлтэс болон Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн эвслийн танилцуулга, мэдээллийг сонсож, санал солилцсон юм. “Сонгуулийн боловсрол” клуб нь сар тутам уулзалт, сургалтыг зохион байгуулж байна.







09

СОНГУУЛЬ ДЭЛХИЙ ДАХИНД

- Узбекистаны ард нийтийн санал асуулгад олон улсын ажиглагчаар оролцсон нь
- Парагвай Улсын 2023 оны ерөнхий сонгуульд хөндлөнгийн ажиглалт хийлээ.
- Ажиглагчийн тэмдэглэл

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

49



УЗБЕКИСТАНЫ АРД НИЙТИЙН САНАЛ АСУУЛГАД ОЛОН УЛСЫН АЖИГЛАГЧААР ОРОЛЦСОН НЬ (ТЭМДЭГЛЭЛ)

А.БАНЗРАГЧДОРЖ

Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн
төвийн референт



Узбекистан улс 2023 оны дөрөвдүгээр сарын 30-ны өдөр O'zbekiston Respublikasi Refendumi буюу Ард нийтийн санал асуулгыг зохион байгуулсан. Уг санал асуулгыг ажиглахаар 16 улсын 120 гаруй ажиглагч оролцсоны хоёр нь Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн Э.Түвшинжаргал болон СЕХ-ны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн референт А.Банзрагчдорж миний бие байв. Узбекистан улс нь шашны улмаас хүний эрхийн нэлээд зөрчилтэй байсныг уг санал асуулгаар өөрчлөхийг зорьжээ. Санал асуулгын хувьд "Та үндсэн хуулийн өөрчлөлтийг дэмжиж байна уу?", "Yes or No" гэсэн агуулгатай. Бидний хувьд олон улсын ажиглагчын багт нэгдэж Узбекистан Улсын Сонгуулийн төв комиссийн байранд ерөнхий мэдээлэл авч, санал хураалтын өдөр буюу 4-р сарын 31-нд санал асуулга явагдаж буй санал авах байртай танилцсан юм.

Узбекистан улсын сонгуулийн төв комисс. /Central election commission of Uzbekistan/




Олон улсын ажиглагчийн багтай хийсэн уулзалт. /Армен улс/



Урьдчилсан санал хураалтын дүн. Узбекистан Улсын сонгуулийн төв комисс анх удаа санал авах байранд хяналтын камер байршуулж, дүрсийг шууд дамжуулж байгаа нь.



Ард нийтийн санал асуулгын санал авах байр.



Сонгогчдын нэрийн жагсаалтыг ингээд хэвлээд тавьчихдаг ажээ. Ард нийтийн санал асуулгын бас нэг онцлог нь ямар нэгэн нэр дэвшигч эсвэл намыг сонгохгүй учраас Узбекистан Улсын Сонгуулийн төв комисс төрийн өмчит компаниудтай хамтран ажилладаг шийдэл байлаа. Ингэснээр улсаас гарах зардлыг хэмнээд зогсохгүй, нийгмийн хариуцлагын асуудал юм. Хэрвээ ард нийтийн санал асуулга манай улсад зохион байгуулагдахаар болвол энэ арга их үр ашигтай санагдлаа.



ПАРАГВАЙ УЛСЫН 2023 ОНЫ ЕРӨНХИЙ СОНГУУЛЬД ХӨНДЛӨНГИЙН АЖИГЛАЛТ ХИЙЛЭЭ

П.АЛТАНЧИМЭГ

Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн ахлах референт

Дэлхийн Сонгуулийн байгууллагуудын холбоо/A-WEB/-ноос Бүгд Найрамдах Парагвай Улсын 2023 оны Ерөнхий сонгуулийг ажиглах багийг 2023 оны дөрөвдүгээр сарын 26-нөөс тавдугаар сарын 1-ний өдрүүдэд Парагвай Улсын нийслэл Асоншин хотноо ажиллуулалаа. Тус холбооны сонгууль ажиглах багт Монгол, Өмнөд Солонгос, Парагвай, Эквадор, Болив, Буркина Фасо зэрэг Улсын сонгуулийн байгууллагын төлөөллүүд оролцсон бөгөөд Монгол Улсаас Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн ахлах референт П.Алтанчимэг миний бие уг ажиглах багт орж ажилласан юм.

Парагвай Улсын сонгуулийн төв байгууллага (Superior Court of Electoral Justice)-с Олон Улсын сонгууль ажиглагчдын 16 багт 3 өдрийн турш мэдээлэл олгох хурлуудыг зохион байгуулав. Сонгуулийн төв байгууллагаас

сонгуулийн хууль эрх зүйн орчин, онцлог, сонгуулийн ерөнхий зохион байгуулалт, автоматжуулсан систем зэрэг сэдвээр мэдээлэл, танилцуулгууд бас хийлээ. Түүнчлэн тус улсын улс төрийн нөхцөл байдал, улс төрийн намуудын үүрэг, оролцоо, сонгогчдын боловсролын асуудлаар нэр дэвшигчид, төрийн бус байгууллага, судлаачидтай ч уулзалт хийв.

2023 оны ерөнхий сонгуулиар Ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчийн сонгууль, Сенатын гишүүн /45/-г сонгох сонгууль, Доод танхимын гишүүн /80/-г сонгох сонгууль, Орон нутгийн удирдлага /17/-г сонгууль болон Орон нутгийн зөвлөлийн гишүүд /257/-ийг сонгох сонгууль гэсэн 5 төрлийн сонгуулийг нэг өдөр зохион байгууллаа.

Ерөнхий сонгуульд 768 мандатын төлөө 26 намын нийт 9095 орчим нэр дэвшигч сонгуульд өрсөлдлөө.

Парагвай Улсын тухайд Сенатын

болон доод танхимын гишүүнийг сонгох сонгуульд хаалттай хувь тэнцүүлсэн тогтолцооноос намын нээлттэй жагсаалт бүхий хувь тэнцүүлсэн тогтолцоо руу шилжиж байгаа. Сонгуулийн автоматжуулсан системийг анх удаа томоохон сонгуульд хэрэглэж буй зэрэг нь олон улсын ажиглагчдын сонирхлыг зүй ёсоор татав.

СОНГУУЛИЙН ОНЦЛОХ ЗАРИМ ЗҮЙЛ:

Сонгогчдын нэрийн жагсаалт: Сонгуулийн төв байгууллага сонгогчдыг бүртгэж, сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлддэг. Иргэд сонгогчдын нэрийн жагсаалтад онлайнаар болон биеэр бүртгүүлэх боломжтой. Сонгогчдын нэрийн жагсаалтад 4.832.186 сонгогч бүртгэгдсэн бөгөөд сонгогчдын 49% /2.372.444/ нь эмэгтэй сонгогч, 51% /2.459.742/ нь эрэгтэй сонгогч байна. 2023 оны ерөнхий сонгуулийн санал хураалтад сонгогчдын 62.03% нь оролцож санал өгчээ.

Тус улс залуучуудын сонгуулийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд 18-29 насны залуучуудыг сонгогчдын нэрийн жагсаалтад автоматаар бүртгэдэг. Энэ насны залуус нийт хүн амын 31 хувийг эзэлдэг. Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогч санал өгөх үүрэгтэй бөгөөд



энэ удаагийн сонгуулиас эхлэн санал өгөөгүй тохиолдолд торгууль /14\$/ төлөхөөр хуульчилсан.

Түүнчлэн мөн сонгуулиас эхлэн гадаад улсад суугаа иргэдийн саналыг шуудангаар авах шинэ зохицуулалтыг хуульдаа оруулжээ. Хоёр сая орчим сонгогч нь гадаадад ажиллаж, амьдардаг. Тэдгээр иргэд сонгогчдын нэрийн жагсаалтад урьдчилан бүртгүүлэх бөгөөд тухайн гадаад улсад 100-аас дээш сонгогч байгаа тохиолдолд санал авах байр байгуулж, санал авах төхөөрөмжөөр санал авна. Цөөн тооны сонгогч бүртгэгдсэн тохиолдолд шуудангаар санал өгнө. Энэ удаа гадаад улсаас 41,505 сонгогч санал өгөхөөр бүртгүүлжээ.

Сонгуулийн зохион байгуулалт:

Парагвайн сонгуулийн санал авах байрны зохион байгуулалт нь манайхаас нэлээд ялгаатай юм. Улсын хэмжээнд 1,157 санал авах төв ажиллаж, эдгээр төвүүд нь дотроо 14-16 санал авах байр/ширээ (Voting table)-г агуулдаг. Нийт 12,259 санал авах байртай, тус бүртээ санал хураалт зохион байгуулах 3 хүний (1 дарга, 2 гишүүн) бүрэлдэхүүнтэй ажилладаг.

Энэ удаагийн сонгуулийн санал хураалт дөрөвдүгээр сарын 30-нд өглөө 07:00-16:00 цагийн хооронд 9 цагийн хугацаанд зохион байгуулагдлаа. Урьдчилсан санал хураалт байхгүй. Эрүүл мэндийн шалтгаанаар санал авах байранд ирж санал өгөх боломжгүй сонгогчдоос гэрээр нь санал авах үйл ажиллагааг санал хураалтын өдөр зохион байгуулав.

Сонгуулийн автоматжуулсан систем:

Парагвай Улс 2023 оны ерөнхий сонгуульдаа анх удаа санал авах, тоолох, дүн нэгтгэх төхөөрөмжийг ашиглалаа. Уг төхөөрөмжийг 2021-2022 онд Орон нутгийн хурлын төлөөлөгчдийг сонгох сонгууль болон намын дотоод сонгуульд ашигласан бөгөөд сонгогчдын 80-90% нь энэхүү төхөөрөмжийг хэрэглэж үзсэн туршлагатай



аж. Сонгуулийн автоматжуулсан системийг баталгаажуулан, шалгах үйл ажиллагаанд улс төрийн бүх нам, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан зохион байгуулав. Санал хураалтын урд өдөр төхөөрөмжийн ажиллагааг урьдчилан шалгахдаа дотоод, гадаадын ажиглагчдыг байлцууллаа. Нийтдээ 15,380 санал авах төхөөрөмж ажиллуулжээ.

Санал авах төхөөрөмжийн хувьд мэдрэгч бүхий дэлгэцтэй, нам, эвсэл болон нэр дэвшигчдийн мэдээллийг агуулдаг. Сонгогч дэлгэцээс улс төрийн аль нэг намыг сонгон, тухайн намаас дэвшиж буй нэр дэвшигчдийн зураг бүхий жагсаалтаас сонголт хийж, саналаа өгнө. Сонгогчийн санал саналын хуудаст хэвлэгдэн/саналын хуудасны чипэнд өгөгдөл хэлбэрээр, мөн саналын хуудаст текст хэлбэрээр хэвлэдэг./ гарах бөгөөд саналын хуудсыг саналын хайрцагт хийснээр сонгогч санал өгч дуусна. Уг төхөөрөмж сонгогчийн саналын мэдээллийг өөртөө хадгалдаггүй, ямар нэг сүлжээнд холбогддоггүй ажээ.

Санал хураалт хаагдсаны дараа төхөөрөмжийн ажиллах горимыг сольж, саналын хуудсыг тоолж эхэлдэг. Саналын хуудас нь өөр дээрээ мэдээлэл бүхий чиптэй. Чипэнд саналын мэдээлэл хадгалагдана. /Саналын мэдээлэл 2 янзаар хадгалагддаг. 1. Хэвлэмэл байдлаар, 2. Чипэнд дата хэлбэрээр/. Тоолох горимд тохируулсан төхөөрөмжид саналын хуудсыг нэг бүрчлэн уншуулж санал авах

байрны нэгдсэн дүнг гаргана. Тоолж дууссаны дараа нэгдсэн дүнг хэвлэж санал авах байрны бүрэлдэхүүн гарын үсэг зурж баталгаажуулдаг. /Нэгдсэн дүнг бүх ажиглагчид хэвлэж өгдөг/

Нэгдсэн дүнг дамжуулах үйл явц:

Санал авах төв /14-16 санал авах байр/ тус бүрд дүн дамжуулах нууцлал бүхий сүлжээнд холбогдсон нэг төхөөрөмж байрлах бөгөөд энэхүү төхөөрөмжөөр санал авах байрууд гарын үсэг зурж баталгаажуулсан тооллогын дүнгээ Сонгуулийн төв байгууллагад шууд дамжуулдаг. Сонгуулийн төв байгууллага хүлээн авсан дүнгээ нэгтгэн сонгуулийн санал хураалтын урьдчилсан дүнг цахим хуудсаар шууд дамжуулах ба 3 цагийн дотор санал авах байрны дүн 92%-тай нэгддэг байна.

Сонгогчдод туслах ширээ: Саналавах төв бүрийн үүдэнд сонгогчдод туслах, мэдээлэл олгох ширээ ажиллуулдаг байна. Энэхүү ширээнд Сонгуулийн төв байгууллагад дадлага хийж буй бэлтгэгдсэн оюутнууд ажиллаж сонгогчдод шаардлагатай туслалцаа үзүүлэх, мэдээлэл өгөх байдлаар ажилдаг. Жишээ нь: сонгогч хэдэн номерын санал авах байранд санал өгөх, санал авах төхөөрөмж дээр хэрхэн ажиллах гэх мэт зөвлөгөө мэдээллийг өгдөг байна.


Бүгд Найрамдах Парагвай Улсын 2023 оны ерөнхий сонгууль нь бидний хувьд суралцах зүйл ихтэй, сонирхолтой зохион байгуулалт бүхий сонгууль байлаа.

АЖИГЛАГЧИЙН ТЭМДЭГЛЭЛ



Б.ИВЭЭЛ

"Сонгогчдын боловсрол төв" ТББ-ын төслийн менежер



Азийн чөлөөт, шударга сонгуулийн сүлжээ /ANFREL/ нь 2022 оны тавдугаар сарын 9-нд Филиппиний бүх нийтийн болон орон нутгийн сонгуульд олон улсын сонгууль ажиглах багийг илгээсэн бөгөөд түүнд Монголоос "Сонгогчдын боловсрол төв"-ийн төлөөлөл орж ажилласан юм.

Филиппины бүх нийтийн болон орон нутгийн сонгуульд нийт 67,442,744 сонгогч бүртгүүлсэн (1,697,215 нь гадаадад оршин суудаг.) 18,100 албан тушаалтанг сонгосон.

Сонгогчдыг нь насны ангиллаар

- 33% (20.4 million) 18-30 нас,
- 52% (32.2 million) 31-59 нас,
- 14% (9.1 million) 60+ нас.

Сонгуулийн ирц нь 2010 онд автоматжуулсан системд шилжсэнээс хойшхи хамгийн өндөр буюу 84.10% байв. Гадаадад бүртгүүлсэн сонгогчдын 38.61% нь саналаа өгсөн байна.

Филиппин нь ерөнхийлөгчийн засаглалтай. Ерөнхийлөгч Засгийн газрын танхимыг томилж, тэргүүлдэг.

Хоёр танхимтай Конгресс нь дээд танхим болох Сенат, доод танхим

болох Төлөөлөгчдийн танхимаас бүрддэг.

18,100 албан тушаалтанг салгаж үзвэл:

Үндэсний хэмжээнд:

- Ерөнхийлөгч,
- Дэд ерөнхийлөгч,
- 12 Сенатор, (Нийт 24, 12 нь дунд хугацааны сонгуулиар сонгогдсон).
- 63 Төлөөлөгчдийн танхимын намын жагсаалтын гишүүд.

Орон нутгийн түвшинд:


- 253 Дүүргээс сонгогдсон Төлөөлөгчдийн танхимын гишүүд,
- 81 Засаг дарга, 81 дэд дарга (аймаг тус бүрт),
- 782 Аймгийн удирдах зөвлөлийн гишүүд (Sangguniang Panlalawigan),
- 146 Хотын дарга, 146 дэд дарга, 1,650 хотын иргэдийн төлөөлөгчид (Sangguniang Panlungsod),
- 1,488 Орон нутгийн захирагч, 1,488 дэд захирагч, 11,908 орон нутгийн иргэдийн төлөөлөгчид (Sangguniang Bayan).

Мөн дөрөвдүгээр сарын 29-нд болсон урьдчилсан санал хураалт болон тавдугаар сарын 10-нд болсон сонгуулийн дүнг танилцуулах үйл ажиллагааг ажигласан.



Орон нутгаас хамаараад нэг сонгогч дунджаар 29 нэр дэвшигч, нэг намыг сонгох ба ойролцоогоор 15 минут зарцуулж байсан.

Саналын хуудас нь 73.5 см урттай учраас нууцлал хадгалахад учир дутагдалтай ажээ.



Сонгогч саналаа тэмдэглээд саналын хуудсаа санал тоолох машинд уншуулсны дараа дүнг хэвлэж өгөх ба сонгогч шалгаад тусгай хайрцагт хийнэ. Буруу сонголт хийсэн, дутуу сонгосноос үл хамаараад дахин саналын хуудас авах боломжгүй байсан.



*Дээрх зураг дээрх саналын хуудас нь сүргалтад зориулсан болно.

Санал авах хугацаа дуусангуут санал авах байр нь хаалгаа хааж, санал тоолох төхөөрөмжөөс тайланг дамжуулах ба намын ажиглагч нарт хэвлэж өгч байсан.



*Энэ зураг нь зөвхөн эхний хэсэг нь бөгөөд тухайн санал авах байранд нэр дэвшигч бүрээр хэдэн санал авсан нь дэлгэрэнгүй харагдаж байна.

Миний хувьд
Филиппиний хойд хэсэг
болох Cordillera болон
Ilocos мужийн Benguet,
Ilocos Sur, Abra, Ilocos
Norte зэрэг дүүрэгт
ажилласан. Ilocos
Norte нь сонгогдсон
Ерөнхийлөгч Ferdinand
"Bongbong" Romualdez
Marcos-ын нутаг
бөгөөд Solid North
буюу Филиппиний хойд
мужуудын Илокано
гаралтай улс төрчдөд,
ялангуяа Маркосын
гэр бүл болон тэдний
холбоотнууд санал
хураалтад ашигладаг
сонгуулийн үзэгдэл юм.

Bongbong Marcos-ын хүчтэй өрсөлдөгч Leni Robredo-гийн дэмжигчид “No More Solid North” гэсэн уриаг ашиглаж байсан.




**Улс төрийн ноёрхлыг зогсоосон нэр дэвшигчдийн тухай мэдээ нийтлэгджээ.*



Сонгуулийн үеэр 7-eleven сүлжээ дэлгүүр нь “албан бус” хөгжилтэй байх зорилготой санал асуулга болох “Speak Cup” буюу ерөнхийлөгчид нэр дэвшигчдийн зурагтай аяга гаргаж, сонгогчид өөрийн дэмжиж буй нэр дэвшигчийн зурагтай аяганд уух зүйлээ хийлгэж авах юм. Нэр дэвшигчээ сонгож амжаагүй байгаа хүмүүст зориулсан “Шийдээгүй” гэсэн бичигтэй аяга ч байв.

ТАНЫ СОНГУУЛИЙН БОЛОВСРОЛД



Сонгогч Та санал өгөх өдөр сонгуульдаа оролцон саналаа өгснөөр төрийн эрх барих эрхээ дөрвөн жилд нэг удаа эдэлдэг болов чиг сонгох, сонгогдох эрх чөлөөгөө зөвхөн санал авах өдрөөр төсөөлөх нь өрөөсгөл хэрэг болох юм. Хариуцлагатай, мэдлэг, мэдээлэлтэй сонгогч нь сонгуулийн өмнө болон сонгуулийн үед, сонгуулийн дараа ч хяналт, оролцоогоо өчүүхэн ч сулруулахгүй, төрийн эрх барих төлөөллөөрөө дамжуулан эрхээ эдэлсээр байдаг. Иймд дараах зөвлөмжийг хэрэгжүүлээрэй.


СОНГУУЛИЙН ӨМНӨ:



Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэх, алдаа мадаггүй эсэхийг шалгах, бүртгэгдээгүй бол Улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх;
www.burtgel.gov.mn



Тухайн сонгуульд оролцож байгаа нам, эвслийн мөрийн хөтөлбөр, алсын хараа, үзэл баримтлал, нэр дэвшигчдийн мэдлэг боловсрол, чадвар, ажлын туршлага зэрэг мэдээллийг хангалттай цуглуулах; www.audit.mn



Цуглуулсан мэдээллээ судлан бусдын нөлөөнд автахгүйгээр нам, эвсэл, нэр дэвшигчдийг харьцуулан үнэлж, дүгнэх чадварт суралцах; www.m-election.mn

СОНГУУЛИЙН ҮЕЭР:



Өөрийн болон улс орны ирээдүйг найдан даатгаж болох, итгэл даах улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийг шилж сонгох;



Сонгуулийн санал авах өдөр сонгуулийн санал авах байр руу очоод саналаа өгөөрэй. Ингээд дууслаа гэж санаа амарч болохгүй!

@Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хороо

СОНГУУЛИЙН ДАРАА:



Сонгосон төлөөллийнхөө үйл ажиллагаанд үнэлэлт өгч, санал, хүсэлт, гомдол, өргөдөл өгч, хяналт, оролцоогоо орхигдуулахгүй идэвхтэй харилцаж, сошиал хаяг болон бусад харилцаа холбооны хэрэгслийг ашиглан хуулийн төсөл, шийдвэр, төсвийн төсөл, орон нутгийн хөгжүүлэх сан зэрэгт саналаа өгч, байр сууриа илэрхийлэн дуу хоолойгоо хүргэж байх; www.parliament.mn D-parliament.mn, <https://president.mn/>, <http://khural.mn/>



Бүрэн эрхийн хугацаа өнгөрсний дараа тэдгээр улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн төлөө дахин санал өгөх эсэхээ шийдээрэй.



АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2023 ОНЫ НӨХӨН СОНГУУЛЬ ЯВАГДАХ ГАЗАР, САНАЛ АВАХ БАЙРНЫ ХАЯГ, БАЙРШИЛ



Орон нутгийн Хурлын нөхөн сонгууль 2023 оны зургадугаар сард: Аймаг, нийслэлийн ИТХ-ын 3, Сум, дүүргийн 40 мандатын төлөө 17 аймаг, 30 сум, нийслэлийн 1 дүүрэгт явагдана.



Санал авах ажиллагаа: 2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 18-НЫ НЯМ ГАРАГТ, Улаанбаатарын цагаар 07:00-20:00 цагт санал авах байранд явагдана.

Д/д	Хэсгийн дугаар	Тойргийн дугаар	Аймаг, нийслэлийн нэр	Сум, дүүргийн нэр	Баг, хорооны дугаар, нэр	Санал авах байрны хаяг, байршил
1	1-5-6	1	Архангай	Их тамир	5-р баг, Тайхар	Соёлын төвд
2	2-7-4	2	Баян-Өлгий	Буянт	4-р баг, Шар тохойт	Ерөнхий боловсролын сургуулийн байранд
3	3-4-2	3	Баянхонгор	Баянговь	2-р баг, Өрхт	Багийн төвд
4	3-6-1	3		Баян-Овоо	1-р баг, Мандалхайрхан	Багийн төвд
5	3-9-1	3		Богд	1-р баг, Луугар	-
6	3-9-2	3			2-р баг, Гурван гол	Цутгалангийн эх
7	3-9-3	3			3-р баг, Алтай	Алтайд
8	3-9-4	3			4-р баг, Цэлгэр	-
9	3-9-5	3			5-р баг, Буянт	-
10	3-9-6	3			6-р баг, Хориулт	-
11	3-16-2	3		Заг	2-р баг, Баян-Улаан	Тосуйд

д/д	Хэсгийн дугаар	Тойргийн дугаар	Аймаг, нийслэлийн нэр	Сум, дүүргийн нэр	Баг, хорооны дугаар, нэр	Санал авах байрны хаяг, байршил
12	4-14-1	4	Булган	Хангал	1-р баг, Сөрт	Соёлын төвийн үзвэрийн зааланд
13	6-1-3	6	Говьсүмбэр	Сүмбэр	3-р баг,	-
14	6-3-1	6		Шивээговь	1-р баг	Сумын ЗДТГ-ын хурлын танхимд
15	6-3-2	6			2-р баг	Соёлын төвийн номын санд
16	8-2-4	8	Дорноговь	Айраг	4-р баг, Цагаан дөрвөлж	Соёл, спортын төвийн спорт зааланд
17	8-14-3	8	Дорноговь	Эрдэнэ	3-р баг, Цагаан хөтөл	Ерөнхий боловсролын сургуулийн шинэ дотуур байранд
18	9-13-1	9	Дорнод	Чойбалсан	1-р баг, Хулстай	Сумын соёлын төвд
19	9-13-4	9			4-р баг, Хөх нуур	Хөх нуур багийн төвд
20	10-2-3	10	Дундговь	Адаацаг	3-р баг, Өвөр-Урт	Багийн төвд
21	10-3-1	10		Баянжаргалан	1-р баг, Шилийн гол	Сургуулийн спорт зааланд
22	10-10-3	10		Өлзийт	3-р баг, Тагт	Багийн соёлын төвд
23	10-13-1	10		Хулд	1-р баг, Шувуутай	Ерөнхий боловсролын сургуулийн хөдөлмөрийн танхимд
24	13-1-8	13		Арвайхээр	8-р баг, Рашаант	-
25	13-18-6	13	Өмнөговь	Хархорин	6-р баг, Жалбаа	Багийн төвд
26	14-8-2	14	Өмнөговь	Ноён	2-р баг, Ганзагад	Сумын соёлын төвд / хуучин/
27	15-11-2	15	Сүхбаатар	Уулбаян	2-р баг, Жаргалант	Сумын төвд
28	15-11-4	15			4-р баг, Жавхлант	Жавхлант багийн төвд
29	16-1-1	16	Сэлэнгэ	Сүхбаатар	1-р баг, Хонгорморьт	Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн байранд
30	16-1-2	16			2-р баг, Цагаан-Эрэг	Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн спорт зааланд
31	16-3-2	16		Баруунбүрэн	2-р баг, Бургалтай	Ерөнхий боловсролын сургуулийн зааланд


д/д	Хэсгийн дугаар	Тойргийн дугаар	Аймаг, нийслэлийн нэр	Сум, дүүргийн нэр	Баг, хорооны дугаар, нэр	Санал авах байрны хаяг, байршил
32	17-15-1	17	Төв	Бүрэн	1-р баг, Төхөм	Соёлын төвд
33	17-15-2	17			2-р баг, Баянцогт	Ерөнхий боловсролын сургуулийн зааланд
34	17-15-4	17			4-р баг, Эрдэнэхангай	Ахмадын байранд
35	17-18-3	17		Заамар	3-р баг, Хайлааст	9 жилийн 2 дугаар сургуулийн зааланд
36	17-18-4	17			4-р баг, Төв	Соёл, спортын цогцолборт
37	17-21-1	17		Өндөрширээт	1-р баг, Баянтуул	Сумын соёлын төвд
38	18-4-2	18	Увс	Давст	2-р баг, Зүүнхөвөө	Шинэ соёлын төвд
39	19-17-1	19		Эрдэнэбүрэн	1-р баг, Баянгол	Баянголд
40	20-4-5	20	Хөвсгөл	Баянзүрх	5-р баг, Бэлтэс	Алтрага /Сумын соёлын төвд/
41	20-12-1	20		Тосонцэнгэл	1-р баг, Мухархөндий	Багийн төвд
42	21-3-4	21	Хэнтий	Батширээт	4-р баг, Норовлин	Соёлын төвд
43	28-4-1	28	Нийслэл	Сүхбаатар	4-р хороо	Нийслэлийн 45 дугаар сургуулийн байранд
Нийт					43 МАНДАТ	

*Сонгогч та сонгох,
сонгогдох эрхээ эдэлж, сонгуульдаа
идэвхтэй оролцоно уу.*

UIH.MN
УИХ АНХЬ САН



ЗӨӨВРИЙН БИТҮҮМЖИЛСЭН САНАЛЫН ХАЙРЦГААР САНАЛ АВАХ АЖИЛЛАГАА



Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуулийн санал авах өдрийн өмнөх өдөр буюу 2023 оны 06 дугаар сарын 17-ны бямба гарагт Улаанбаатарын цагаар өглөө 09:00-20:00 цагийн хооронд зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал авах ажиллагаа явагдана.

Дараах сонгогчийг зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөхийг хуулиар зөвшөөрсөн байдаг. Үүнд:

- Эрүүл мэндийн байдлын улмаас санал авах байранд өөрийн биеэр очиж чадахгүй сонгогч;
- Дайчилгааны тухай хуульд заасны дагуу нийтийн дайчилгаанд хамрагдан ажиллаж байгаа сонгогч;
- Зөрчлийн улмаас саатуулагдсан, баривчлагдсан сонгогч;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу баривчлагдсан, цагдан хоригдсон сонгогч.

- Сонгогчийн хүсэлт, эмнэлгийн магадалгаа, эсвэл холбогдох байгууллагын тодорхойлолтыг үндэслэн зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авдаг.

Эрүүл мэндийн байдлын улмаас зөөврийн битүүмжилсэн хайрцгаар санал өгөх сонгогч өөрийн эрүүл мэндийн талаарх харьяа өрхийн эмчийн магадалгаа, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх хүсэлтийн хамт санал авах өдрөөс гурваас доошгүй хоногийн өмнө буюу 2023 оны 06 дугаар сарын 15-наас өмнө хэсгийн хороонд хүргүүлнэ. Хэрвээ уг сонгогч асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй бол харьяа баг, хорооны Засаг дарга түүний хүсэлт, мэдээллийг холбогдох хэсгийн хороонд хүргүүлэх үүрэгтэй. Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогчдын нэрийн жагсаалтад ороогүй сонгогчийн саналыг зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар авахыг хориглодог.

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААТАЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТ



Орон нутгийн Хурлын сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлүүлж, санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу санал авах өдрийн

өмнөх өдрийн 00:00 цагаас өмнө зогсоох хуулийн зохицуулалттай. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд сонгуулийн

сурталчилгааг дараах арга, хэлбэрээр явуулахыг зөвшөөрсөн байдаг. Үүнд:

1



Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах;

2



Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байрлуулах;

3



Хуульд өөрөөр заагаагүй бол намын далбааг гудамж талбайд байрлуулах, таних тэмдэг, уриа ашиглах;

4



Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх;

5



Ухуулах байр ажиллуулах;

6



Радио, телевизийн сурталчилгааны нэвтрүүлэг ашиглах;

7



Цахим орчин ашиглах;

8



Өдөр тутмын болон бусад сонин, сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал нийтлүүлэх юм.



СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ХЭВЛЭМЭЛ МАТЕРИАЛ ХЭВЛҮҮЛЭХ, ТАРААХ, ХҮРГЭХ

Сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материалыг дараах хэлбэр, хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр сонгогчдод тараах эрхтэй. Үүнд:

1. Гурван хэвлэлийн хуудас сонин;
2. Гурван хэвлэлийн хуудас сэтгүүл;
3. Нэг хэвлэлийн хуудас ухуулах хуудас.

Ухуулах хуудас болон зурагт самбар байрлуулах байршлыг тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал **санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө тогтоож, нийтэд мэдээлнэ.** Байршлыг тогтоохдоо аливаа нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр заахыг хориглодог. Тогтоосон байршлаас өөр газарт зурагт самбар, ухуулах хуудас байршуулах хориотой.

Харин сонгуулийн сурталчилгаанд ашиглах зурагт самбар, дэлгэцийн хувьд нэг хэсэгт 10-аас илүүгүй тооны, хоёр хэвлэлийн хуудаснаас илүүгүй хэмжээтэй, тогтоосон байршилд түр хугацаагаар, үнэ төлбөргүй байрлуулах боломжтой. Бизнесийн зорилгоор байнга ашиглагддаг сурталчилгааны самбар, дэлгэц, түүний орон зайг сонгуулийн сурталчилгаанд ашигладаггүй.

Сурталчилгааны хугацаанд нам, эвсэл, нэр дэвшигчийн зурагт болон ухуулах хуудас, зурагт самбар, дэлгэцийг гэмтээх, устгахыг хориглодог.

Сонгуулийн уулзалт, хурал, цуглаан хийхэд зориулж, өөрийн эзэмшиж байгаа соёлын төв, биеийн

тамирын болон хурлын заал, бусад байр, танхимыг үнэ төлбөргүй ашиглуулахыг төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, шүүх, прокурор, тагнуул, цагдаа, онцгой байдлын болон эмнэлгийн байгууллагаас бусад төрийн болон орон нутгийн өмчийн 51 хувь ба түүнээс дээш оролцоотой хуулийн этгээд, албан тушаалтанд үүрэг болгосон байдаг.



УХУУЛАХ БАЙР АЖИЛЛУУЛАХ

Нэр дэвшигч сонгуулийн хэсэг бүрд хоёроос илүүгүй ухуулах байр ажиллуулах боломжтой. Ингэхдээ нэг нам, эвслээс нэр дэвшигчид хамтран үйл ажиллагаа явуулахыг хуулиар зөвшөөрдөг.



СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНД РАДИО, ТЕЛЕВИЗ АШИГЛАХ

Радио, телевиз нь сонгогчдын боловсролд зориулсан мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг, хөтөлбөр бэлтгэж түгээх үүрэгтэй байдаг.

Олон нийтийн радио, телевиз сурталчилгааны нэвтрүүлгийг Харилцаа холбооны зохицуулах хорооноос тогтоосон хуваарь, цагийн дагуу үнэ төлбөргүйгээр нэвтрүүлнэ. Радио, телевизийн мэдээллийн хөтөлбөрөөр нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар гарсан мэдээ нь сурталчилгааны нэвтрүүлгийн хугацаанд хамаарахгүй хэдий ч хоногт 5 минутаас илүү хэмжээтэй

мэдээ цацахыг хориглодог.

Сурталчилгаа явуулсан хэвлэл мэдээллийн байгууллага нь сурталчилгаа дууссанаас хойш 10 хоногийн дотор тайлангаа нийтэд мэдээлэх үүрэгтэй бол ХХЗХ сонгуулийн сурталчилгааны төлбөргүй нэвтрүүлгийн хуваарь, цаг, нэвтрүүлэх зөвшөөрөл олгосон радио, телевизийн жагсаалтыг сонгуульд оролцогч нам, эвсэл, бие даан нэр дэвшигчид хүргүүлж, цахим хуудастаа байршуулан нийтэд мэдээлдэг.



СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНД ЦАХИМ ОРЧИН АШИГЛАХ

Сонгуулийн сурталчилгаанд дараах хэлбэрийн цахим хуудас ашиглаж болно гэж хуульчилсан байдаг. Үүнд:

1. Нам, эвслийн болон нэр дэвшигчийн өөрийн тус бүр нэг цахим хуудас;
2. Цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудас;
3. Бусад цахим хуудас.

Нэр дэвшигч сонгуулийн сурталчилгаанд ашиглах цахим хуудсыг нэр дэвшигчийн үнэмлэх авсан өдрөөс хойш **гурав хоногийн дотор тухайн аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд бүртгүүлэх** үүрэгтэй. Цахим хуудас ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулахдаа **сэтгэгдэл бичигдэхгүй** тохиргоотойгоор нийтлэх ёстой. Бүртгүүлээгүй цахим хуудсыг сурталчилгаанд ашиглах, бусдын нэр болон хуурамч хаяг ашиглахыг хуулиар хориглодог.



ХУУЛЬ БУС СУРТАЛЧИЛГААГ ХОРИГЛОХ


Орон нутгийн Хурлын ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдрийг дуустал, нөхөн, ээлжит бус сонгуулийн тухайд сонгууль товлон зарласан шийдвэр гарснаас хойш санал авах өдрийг дуустал аливаа этгээд сонгуулийн сурталчилгаа хийх, сонгогчдын саналыг татах зорилгоор болон дараах үйлдэл, үйл ажиллагаа явуулахыг хориглодог.

Үүнд:

1. Мөнгө, эд зүйл тараах, бараа, эд зүйл хөнгөлөлттэй үнээр худалдах, аливаа үйлчилгээг хөнгөлөлттэй болон үнэ төлбөргүйгээр үзүүлэх;
2. Нийтийг хамарсан биеийн тамирын уралдаан, тэмцээн, баяр наадам, урлагийн тоглолт, хүлээн авалт, дайллага, цайллага, төлбөрт таавар, бооцоот, мөрийтэй тоглоом зохион байгуулах, ивээн тэтгэх;
3. Сонгогчийг гадаад, дотоодод аялал зохион байгуулан оролцуулах, амралт, сувилалд амрах, сувилуулах;
4. Ирээдүйд өөрийн болон бусдын хөрөнгөөр мөнгө, эд бараа өгөхөөр гэрээ байгуулах, хэлцэл хийх;
5. Хишиг, хувь, хувьцаа өгөх, ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэрэг амлалт авах;
6. Сонгуульд оролцохоос татгалзахыг болон сонгуулийн хууль тогтоомж зөрчихийг уриалсан агуулга бүхий сурталчилгаа явуулах;
7. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин, мессеж ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулах, нийтлэх.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТ



Сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд үндэслэн үйлдэх бөгөөд түүнийг нягтлан шалгах, давхардлыг арилгах, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй сонгуулийн эрх бүхий иргэнийг бүртгэх, эдгээртэй холбоотой гомдлыг шийдвэрлэх ажлыг улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангах үүрэгтэй.

Сонгогчдын нэрийн жагсаалтад тухайн сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэл бүхий сонгогчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, иргэний бүртгэлийн дугаар, байнга оршин суугаа газрын хаяг гэсэн дарааллаар бичигддэг. Улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага сонгогчдын нэрийн жагсаалтад байгаа сонгуулийн эрх бүхий

иргэний эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, иргэний бүртгэлийн дугаар, байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн мэдээллийг аймаг, сум, баг, нийслэл, дүүрэг, хороогоор болон сонгуулийн хэсэг нэг бүрээр нь нэгтгэн гаргах бөгөөд уг жагсаалтыг санал авах өдрөөс 90-ээс доошгүй хоногийн өмнөөс буюу 2023 оны 03 дугаар сарын 20-ноос эхэлж орон нутгийн Хурлын сонгууль дуустал өөрийн цахим хуудаст байршуулна. Иргэн Та АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2023 ОНЫ НӨХӨН сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт дахь мэдээлэлтэй танилцах боломжтой.

Сонгогчдын нэрийн жагсаалт дахь мэдээллийг УБЕГ-ын цахим хуудсаас шалгана уу.

<https://election.burtgel.gov.mn/>

СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТАД БҮРТГЭЛТЭЙ ЭСЭХЭЭ ЯАЖ ШАЛГАХ ВЭ?

УБЕГ-ын цахим хуудаст сонгогчдын нэрийн жагсаалтыг байршуулсан байдаг. <https://election.burtgel.gov.mn/>

НЭР ДЭВШИГЧДИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ХААНААС ОЛЖ ҮЗЭХ ВЭ?

Үндэсний аудитын газрын цахим хуудас буюу www.audit.mn цахим хуудсаас үзэх боломжтой.



ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧ ГЭЖ ХЭН БЭ?

Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд Иргэдийн нийтийн хурал байдаг. Манай улсад 21 аймгийн 771, нийслэлийн 45, 330 сумын 7062, 9 дүүргийн 291 мандатад нийт 8169 төлөөлөгч сонгогджээ. Баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлын Зөвлөлд 8000 гаруй хүн сонгогдон ажиллаж байна. Тойргийнхоо иргэдийн итгэлийг хүлээж Хурлын төлөөлөгчөөр сонгогдсон төлөөлөгч нь орон нутгийн эдийн засаг, нийгмийн асуудлыг шийдвэрлэх бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийг хянах, иргэдийн ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулахад оролцох үүрэгтэй. ИТХ-ын төлөөлөгч нь:

- Асуудал хэлэлцэн шийдвэрлэхэд таслах эрхтэй оролцох;
- Хурлын хороонд харъяалагдах;
- Хэлэлцэж байгаа асуудлаар асуулт асууж, хариулт авах, санал, дүгнэлт гаргах, санал хураалгах;
- Хуралд тодорхой асуудал хэлэлцүүлэхээр санаачлах, санал оруулах;
- Хурлаас байгуулсан байгууллага, сонгосон буюу томилсон албан тушаалтны илтгэл, сонсголыг хэлэлцэх, санал гаргах;
- Хурлын шийдвэрийг сонгогчдод тайлбарлан таниулах;
- Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засгийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан Засаг даргад асуулт, асуулга тавих;
- Сонгогчидтой байнга холбоотой ажиллан өргөдөл, санал, гомдлыг нь шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжилж, хариуг хуульд заасан хугацаанд авах;
- Үйл ажиллагаагаа жилд 1 удаа сонгогчдод тайлагнах;
- Нийтийн сонсгол явуулах хүсэлт гаргах.

ИТХ-ын нэгдсэн цахим хуудас: <http://khural.mn/> -аас дэлгэрэнгүй мэдээлэл авна уу.





УИХ-ЫН
СЭДЭЛГЭЭНИЙСЭН



**МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН
ЕРӨНХИЙ ХОРОО**

Засгийн газрын 11 дүгээр байр
Ж.Самбуугийн гудамж,
Улаанбаатар – 15141, Монгол Улс

Санал хүсэлт хүлээн авах хаяг:

gecm@m-election.mn
(976) -51 262127

UHH.MN
СҮНДЛЭГ ААНД САН